# **"ТӨРӨӨС ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНУУД, СУДЛААЧДАД ОЛГОДОГ ТЭТГЭЛЭГ /** СТИПЕНД/**, ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ТАЛААРХИ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ"** (Харьцуулсан судалгаа)

*Ц. Норовдондог (Ph.D), П. Амаржаргал, Ц. Болормаа, Г. Гэрэл,*
*Д. Жигваагүнсэл, Ө. Мөнхтунгалаг, О. Нарантуяа*

**Агуулга**

**Оршил**

**Судалгааны зорилго**

**ОХУ -ын туршлага**

- ОХУ -д оюутнуудад төрөөс үзүүлж буй дэмжлэг, түүний төрөл
- Боловсролын зээл
- Стипенд
- Суралцагсдад үзүүлдэг бусад төрлийн материаллаг дэмжлэг

**Япон улсын туршлага**

- Боловсролын салбарт оюутанд үзүүлдэг санхүүгийн дэмжлэг, тогтолцоо түүний эрх зүйн үндэслэл
- Тэтгэлгийн зээлийн төсөв /хүснэгтээр/
- Зээл болон зээлийн эргэн төлөлттэй холбогдох асуудлууд
- Сургалтын төлбөрөөс чөлөөх

**Швед улсын туршлага**

- Шведийн сургалтын дэмжлэгийн систем
- Швед улсын боловсролын салбар дахь төрөөс үзүүлж дэмжлэгийн зохицуулалт /хүснэгтээр/

**Турк улсын туршлага**

- Эрх зүйн үндэслэл
- Оюутны дэмжлэг тусламжийн төрлүүд:
  - Зээл
  - Буцалтгүй тусламж, тэтгэлгүүд (grant)
  - Бусад дэмжлэг, тусламжууд

**АНУ -ын туршлага**

- Холбооны Засгийн газраас оюутнуудад үзүүлдэг тусламж дэмжлэгүүд/ хүснэгтээр/

**АНГЛИ улсын туршлага**

- Буцалтгүй тусламж, тэтгэлэг /Grant/
- Зээл

**БНХАУ -ын туршлага**

- **Төрийн дэмжлэгийн хэлбэр**
  - Тэтгэлэг

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

- Зээл
- Сургалтын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт
- Оюутны сургалтын мөнгөн шагнал
- Оюутныг дэмжих мөнгөн шагнал
- Оюутны халамжийн тэтгэлэг

**БНСУын туршлага**

- БНСУ -ын дээд боловсролын тогтолцоо
- БНСУ -ын оюутны зээлийн төрөл /хүснэгтээр/
- БНСУ -ын их дээд сургуульд дотоодын болон гадаадын оюутнуудын тэтгэлгээр сурах боломж /хүснэгтээр/

* * *

**Оршил**

Хөгжингүй орнуудын тухайд боловсролын системийн үүрэг роль, ач холбогдолыг  нийгэм-эдийн засгийн хөгжлийн гол хүчин зүйл бөгөөд эдийн засгийн өсөлт нь мэдлэгийн хуримтлал, капиталын хуримтлалаас ихээхэн шалтгаалдаг хэмээн үзэж төрөөс  боловсролын салбар, тэр тусмаа дээд боловсролын салбартаа ихээхэн анхаарч дэмжлэг үзүүлдэг байна.

Ялангуяа дэлхий даяар глобалчлагдаж байгаа өнөө цаг үед боловсролын чанарыг сайжруулсанаар нэг талаас  улс орон бүр дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах, нөгөө талаас үндэсний боловсрол, соёлын  үнэт зүйлээ хадгалах, баяжуулан хөгжүүлэх зорилгыг агуулж байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн бүх улс орнууд боловсролын системийг санхүүжүүлэх эх үүсвэрээ нэмэгдүүлэх, улс орны хөгжилд  зайлшгүй хэрэгцээтэй мэргэжилтнүүдийг уян хатан бодлогоор бэлтгэх зэрэгт ихээхэн анхаарал хандуулж байна. Аль ч улсын төр засаг боловсролын салбарт төрөөс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэхийн төлөө байна. Тухайлбал, Боловсролын салбарт дэлхийд тэргүүлдэг Герман, Франц, Их Британи улсын боловсролын салбарын санхүүжилтийн 80% -иас дээш хувийг төрөөс гаргадаг байна.

Боловсролын систем өндөр хөгжсөн АНУ-д  боловсролын салбарын төсвийн санхүүжилт 50%-иас доош байна.  Финлянд, Швед зэрэг улсууд  Европын боловсролын системд тэргүүлэх байр суурийг эзэлдэг лидер улс бөгөөд боловсролын системээ үнэ төлбөргүй байхаар хуульчилсан нь  нийгмийн  бахархал болоод зогсохгүй боловсролын чанарын жишиг,  баталгаа болж байна.

1970-аад оныг хүртэл АНУ болон ЗХУ дэлхий дээр боловсролын салбарт зарцуулдаг хөрөнгөөрөө  тэргүүлэгч гүрнүүд байлаа.  Энэ үед ОХУ  боловсролын салбартаа Үндэсний нийт бүтээгдэхүүнийхээ 10 - 12%-ийг зарцуулж байв. Гэвч ЗХУ задарч, нийгмийн шинэчлэлийг хэрэгжүүлж  эхэлсэнээс хойш  боловсролын салбарт зарцуулах хөрөнгийн хэмжээ багассаар 1995 он гэхэд төсвийн зарлагынхаа 3,6% -ийг, үүнээс зөвхөн - 2%-ийг дээд боловсролд зарцуулж байсан боловч 1996 оноос эхлэн  боловсролын салбартаа шинэчлэлт хийж,  зорилтот хтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэнээр боловсролын систем, тогтолцоо, төрөөс үзүүлэх дэмжлэгийн хэлбэр, санхүүжилтийг тодорхой болгосноор шинэчлэл үр дүнд хүрч байна.

Орчин үеийн боловсролын системд, ялангуяа шилжилтийн эдийн засагтай орнуудын хувьд шийдвэрлэх  шаардлагатай тулгамдсан асуудлууд олон байна. Тухайлбал, нэг талаас зах зээлийн  шаардлагаар олон янзын мэргэжилтэй боловсон хүчний эрэлт бий

UIH.MN СУДЛАН ШИНЖЛЭСЭН

болж байгаа боловч нөгөө талаас их дээд сургуулиуд болон оюутнуудын тоо эрс өсч чанаргүй сургалт, “ажлын байргүй мэргэжилтнүүд”-ийн арми бүрдэж байна. Хандлагаас харахад эдийн засаг, хууль , менежмент зэрэг ерөнхий мэрэгжилтнүүдийн тоо өсч байгаа боловч суурь шинжлэх ухаан, техникийн шинжлэх ухаан, анагаах ухаан, онолын физик, атомын эрчим хүч, сансар огторгй судлал зэрэг нарийн мэргэжлийн мэргэжилтнүүд хомсдсоноос шинжлэх ухаан, эдийн засгийн хөгжлийн суурь салбарууд эзэнгүйдэж, мэргэжлийн боловсролын бодлого алдагдахад хүрчээ.

Ямар ч үнээр хамаагүй дээд боловсролын дипломтой болох эрмэлзэл ихэссэн учраас их, дээд сургуулиудад суралцах төлбөртэй оюутны тоо нэмэгдэж боловсролыг бизнес болгон хувиргасан өнөөгийн тогтолцоог өөрчилж төрийн бодлогоор, чанартай мэргэжилтнүүдийг бэлтгэх, оюутан хүн стандарт орчинд, төрийн дэмжлэгтэйгээр сайн сурч, чанартай боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлэх нь төрийн үүрэг юм.

Цаашид их дээд сургуулиудыг зөвхөн хувийн хөрөнгө оруулалтаар зардлаа санхүүжүүл гээд орхиж болохгүй нь тодорхой бөгөөд дэлхийн бусад орнуудын жишгээр оюутнуудад төрөөс олгодог стипенд, тэтгэлэг, төрийн сангийн зээл зэрэг хөнгөлөлт, дэмжлэгийн тухай асуудлыг судалж, эрх зүйн орчны хүрээнд мэдээлэл бэлтгэв.

Энэхүү судалгаа нь УИХ-ын Тамгын газраас Судалганы төвөөс өмнө нь гүйцэтгэсэн” Төрөөс боловсролын салбарт үзүүлэх дэмлжэг туслалцаа, оюутны тэтгэлгийн асуудлаархи бусад орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалт” харьцуулсан судалгааны 2-р хэсэг буюу үргэлжлэл юм.

**Судалгааны зорилго**

Олон улсын байгууллагын зөвлөснөөр, аль ч улс орон төсвийн хөрөнгийнхөө тодорхой хувийг зайлшгүй дээд боловсролын санхүүжилтэнд хуваарилах ёстой бөгөөд “Боловсролын салбарт төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ нь ДНБ-ны 4-6% байх ёстой. Үүнээс их дээд сургуулиудад зарцуулах хөрөнгө нь боловсролын салбарт зарцуулж буй хөрөнгийн 15-20% байх шаардлагатай” гэсэн нийтлэг зөвлөмж байдаг байна. Үүнтэй уялдуулан төрөөс дээд боловсролын салбарт оюутны амьдрах, сурах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн стипенд, зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламж зэрэг санхүүгийн дэмжлэг ямар байдаг талаархи бусад орнуудын туршлагыг харьцуулан судлав.

Бусад орнуудын туршлагаас харахад, Финлянд, Швед, Герман зэрэг Европын зарим орнуудад үнэ төлбөргүй дээд боловсрол эзэмшүүлэх систем үйлчилж байхад, ОХУ зэрэг томоохон гүрнүүд хуучин социалист системийн үед төрөөс үзүүлж байсан стипендийн системээ халаагүй бөгөөд харин ч боловсронгуй болгох, нэр төрөл, зарцуулах хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэх, “төсвийн” болон “хувийн зардлаар” суралцагч оюутнуудын тоог мэргэжлийн боловсон хүчний бодлого, чанартай уялдуулах талаар томоохон шинэчлэлт хийж байна. Харин АНУ, Австрали, Япон, Хятад, Солонгос зэрэг зах зээл өндөр хөгжсөн орнуудад улсын болон сургуулийн, нэрэмжит, халамжийн гэх мэтийн олон төрлийн тэтгэлэг, грант, оюутны хөнгөлөлт, материаллаг дэмжлэг гэх мэтийн тусгай зориулалт, шалгуур, нөхцөлтэй, төрөл бүрийн тэтгэлгийн системүүдийг төлөвшүүлсэн байна.

Манай орны хувьд төрөөс зарим төрлийн оюутнуудад сургалтын зээл, тусламжийг хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж хэлбэрээр олгохоор журам тогтоосон хэдий ч хэрэгжүүлэх механизм тодорхойгүй, санхүүгийн эх үүсвэр хүрэлцээгүй, хүртээмж муу зэргээс шалтгаалан оюутнуудад энэ нь төрөөс үзүүлж байгаа бодитой дэмжлэг болж чадахгүй байна.

Анхан, дунд, дээд шатны мэргэжлийн боловсрол эзэмшигч, оюутан, судлаачид, шинжлэх ухааны салбарын судлаач шинжээчдэд зориулан Ерөнхийлөгчийн болон Засгийн

газрын стипенд, академик сургалтын улсын стипенд, нэрийн стипенд, тусгай тэтгэлэгүүд, халамжийн стипенд, материаллаг тусламж зэрэг олон төрлийн дэмжлэг туслалцаа үзүүлдэг тогтсон системүүд дэлхий дээр төлөвшсөн болохыг бид энэхүү судалгааны явцад олж тодруулахыг зорьсон болно.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### "ТӨРӨӨС ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНУУД, СУДЛААЧДАД ОЛГОДОГ ТЭТГЭЛЭГ, ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ТАЛААРХИ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ"

### ОХУ -ын ТУРШЛАГА

ОХУ-д боловсролын системийн шинэчлэл нь нэлээд өргөн цар хүрээг хамран бодлогын томоохон зорилтот хөтөлбөрөөр дамжин хэрэгжиж байна. /Федеральная целевая программа развития образования на 2006-2010 годы, утвержденная постановлением Правительства РФ от 23 декабря 2005г. № 803/
ОХУ нь 2003 оноос дээд боловсролын шаталсан тогтолцооны Болонийн системд шилжиж эхэлсэн бөгөөд 2010 он гэхэд дээд боловсролын систем нь Европын боловсролын стандартад шилжиж "Европын" сургалтын хөтөлбөрт шилжихээр бэлтгэл хангаж байна.
ОХУ-ын дээд боловсролын эрх зүйн үндсэн баримт бичиг нь 1996.10.22-ны өдөр батлагдсан "Дээд боловсрол болон мэргэжлийн боловсролын тухай" Холбооны улсын хууль болон түүний нэмэлт өөрчлөлтүүд юм. Энэ хуулиар ОХУ-ын боловсролын систем нь бакалавр, магистрын систем болон мэргэжлийн боловсрол олгох боловсролын системийн шаталсан тогтолцоонд шилжиж байна.

ОХУ-ын Засгийн газрын 1994 оны 10сарын 12-ны өдрийн 940-р тогтоолоор ОХУ-ын Дээд боловсролын улсын стандартыг тогтоосон байна. Үүнд:

1. Бүрэн бус дээд боловсрол /анхан, дунд түвшний мэргэжлийн боловсрол/
2. ИДС-ийн мэргэжлийн боловсрол олгох программыг бүрэн хангасан бакалавр /4 жилээс доошгүй суралцах/
3. "Мэргэжилтэн" буюу мэргэшсэн диплом авах
4. ИДС-ийн үндсэн хөтөлбөрийн дагуу суралцаж бакалаврын суурин дээр магистрын зэрэг авах

   2007 онд ОХУ-ын Холбооны улсын хуулиар дээд мэргэжлийн боловсролын шаталсан систем болон нормативт суралцах хугацааг тогтоосон. Үүнд:

   - Дээд мэргэжлийн боловсрол - Бакалавр / 4 жил/
   - Дээд мэргэжлийн боловсрол - Мэргэжилтэн /5-аас доошгүй жил/ эсвэл Магистр /бакалавр + 2 жил, нийт 6 жил /

Боловсролын салбарын үр шим нь нийгмийн хөгжлийг тодорхойлогч хүчин зүйл болдог учраас ОХУ-д мэргэжлийн боловсролын суралцагсад, оюутан, аспирант, докторант зэрэг бүх суралцагсаддаа оюутны стипенд, зээл, тусламж үзүүлдэг уламжлалт тогтолцоогоо хадгалж, дэмжлэг туслалцааны төрлүүд, зарцуулах хөрөнгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх талаар ихээхэн анхаарч байна. Одоо мөрдөж байгаа ОХУ-ын хууль тогтоомжоор дараахь төрлийн оюутны зээл, стипенд, тусламжийг оюутнууддаа олгож байна.

<u>**ОХУ-д оюутнуудад төрөөс үзүүлж буй дэмжлэг**</u>

1. **Боловсролын зээл.**

Сүүлийн 2 жилд хэдийгээр хүү багатай боловсролын зээл олгож эхэлсэн боловч энэ нь төдийлөн үр дүнтэй биш байна. Иргэдийн амьжиргааны түвшин, цалин хөлс бага

UIH.MN СУДАЛГААНЫ САН

байгаа учраас орлого багатай өрхийн оюутнууд энэхүү зээлд хамрагдаж чадахгүй байна. Нөгөө талаас хүү багатай боловсролын зээл олгох санхүүгийн эх үүсвэр хомсдолтой байна. /Хавсралт-ОХУ-ын боловсролын зээлийн журам - Постановление правительства РФ от 23 августа 2007г. №534 "О проведении эксперитента по государственной поддержке предоставления образовательных кредитов студентам образовантельных учреждений, высшего профессионального образования, имеющих государственную аккредитацию"/

## 2. Стипенд

Стипенд бол төрөөс оюутнуудад үзүүлж байгаа баталгаатай дэмжлэгийн нэг хэлбэр юм. Төрөөс оюутнуудад үзүүлж байгаа дэмжлэгт стидендээс гадна хууль эрх зүйн актаар баталгаажсан зарим төрлийн материаллаг дэмжлэгүүд орно.

Судалгааны хүрээнд ОХУ-ын хууль, тогтоомжоор тусгайлан олгож байгаа стипенд болон бусад төрлийн дэмжлэг, түүний хэмжээ, төсвөөс хэрхэн санхүүжүүлдэг, стипендэд татвар оногдуулдаг эсэх, зэрэг нэлээд нарийвчилсан мэдээллийг өгөхийг зорилоо.

ОХУ-н хууль тогтоомжоор, СТИПЕНД гэдэг бол боловсролын байгууллага болон шинжлэх ухааны байгууллагуудын өдрийн ангид сурдаг оюутан, аспирант, докторантуудад олгодог мөнгөн төлбөр юм. Дараахь төрлийн стипендүүдийг ОХУ-д олгодог байна. Үүнд:

- ✓ ОХУ-ын Ерөнхийлөгчийн стипенд
- ✓ ОХУ-ын Засгийн газрын тусгай стипенд
- ✓ Аспирант болон докторантуудад зориулсан улсын стипенд
- ✓ Академик сургалтын улсын стипенд
- ✓ Нэрийн стипенд
- ✓ Улсын нийгмийн халамжийн стипенд

Холбооны улсын хувьд нийт олгодог стипендийн төрлийг схемчлэн үзүүлбэл:




Мөн 2008 оны 1 сараас эхлэн Холбооны улсын боловсролын байгууллагын Мэргэжлийн анхан шатны боловсролын стипенд, цэргийн сургуулийн сонсогчид болон цэргийн албанд дайчлагдсан гэр бүлийн хүүхдийн оюутны стипенд ийг олгож эхэлсэн байна.

Стипендийн төрлүүд болон олгох журам нь өөр өөрийн гэсэн онцлогтой. Стипендийн хэмжээг Холбооны улсын хэмжээнд тогтоох бөгөөд ОХУ-ын бүрэлдэхүүн субьект болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хувьд эрх бүхий байгууллага нь стипендийн хэмжээг тогтоож болох боловч энэ нь Холбооны улсын боловсролын байгууллагын тогтоосон хэмжээнээс бага байж болохгүй, өөр төрлийн стипенд мөн байж болохоор заасан байна.

**ОХУ-ын Ерөнхийлөгчийн стипенд**

ОХУ-ын интеллектуал потенциалыг хадгалах болон хөгжүүлэх зорилгоор ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1993 оны 04 сарын 12-ны өдрийн 443-р зарлигаар батлагдсан журмын дагуу энэхүү стипендийг олгож эхэлсэн байна. /Зарлиг болон жрумыг хавсаргав/

Энэхүү журмаар стипенд тогтоох болон олгох журмыг зохицулсан байна. Журамд зааснаар стипенд авагч нь сурлага болон шинжлэх ухааны судалгааны ажилд өндөр амжилт гаргасан, тэр нь диплом /болон бусад баримт бичгээр/ баталгаажсан, бүх Оросын болон олон улсын олимпиад, конкурс уралдаан, фестивальд амжилт гаргасан, эсвэл 2 буюу түүнээс дээш техникинй зохион бүтээл гаргасан, гадаад дотоодын төв хэвлэлүүдэд 2-оос дээш шинжлэх ухааны нийтлэл хэвлүүлсэн байх зэрэг шаардлагыг хангасан оюутан болон аспирант байна гэж заажээ.

Стипендийг 09 сарын 01-ний өдрөөс эхлэн оюутнуудад 1 жилийн хугацаатай, аспирантуудад 1-3 жилийн хугацаатай олгодог байна. Оюутан болон курсантуудад жилд 1600руб, аспирантуудад-3000 руб олгодог байна.

**ОХУ-ын Засгийн газрын тусгай стипенд**

Энэ төрлийн стипендийг ОХУ-ын Засгийн газрын 309 тоот тогтоолоор баталсан журмаар олгодог ба стипендийг дээд болон дунд түвшний мэргэжлийн боловсролын сургуулийн өдрийн ангид сурдаг оюутан, аспирантуудад сурлага болон шинжлэх ухааны ажилдаа гаргасан амжилтыг үндэслэн олгодог байна. Ингэхдээ тухайн курсийн сурлагын амжилтыг бүхэлд нь болон эсвэл зарим тодорхой хичээлээр үзүүлсэн амжилтыг үнэлж олгодог байна. Стипендэд нэр дэвшигчийг Улсын ИДС-ийн 3-р курсээс, Улсын дунд мэргэжлийн сургуулийн 2-р курсээс эхлэн Эрдмийн зөвлөлөөс нэр дэвшүүлнэ. Аспирантууд 2-р курсээс эхлэн нэр дэвшүүлэх боломжтой.

Стипендийг 09 сарын 01-нээс эхлэн өнгөрсөн оны оюутны шалгалтын дүн, аспирантуудын жил бүрийн аттсетацийн дүнг харгалзан олгоно.

ОХУ-ын Засгийн газрын *от 14.07.2006 N 430 “О специальных государственных стипендиях Правительства Российской Федерации для аспирантов и студентов, обучающихся в федеральных государственных образовательных учреждениях высшего и среднего профессионального образования”* журмын дагуу аспирантууд -3000 руб, ИДС-ийн оюутнууд-1200 руб, Дунд мэргэжлийн сургуулийн оюутнууд -700 руб авах эрхтэй.

**Аспирант, докторантуудын стипенд**

Энэ төрлийн стипендийг боловсролын болон шинжлэх ухааны байгууллагад суралцаж буй аспирант, докторантуудад төсвийн хөрөгөөр санхүүжүүлж олгоно. Постановлением Правительства РФ от 16.07.2005 N 436 “*О стипендиях аспирантам и докторантам государственных образовательных учреждений высшего профессионального образования и научных организаций*” журмаар аспирантуудад -1500 руб, докторантуудад -3000 руб олгодог байна.

**Академик сургалтын улсын стипенд**

Энэ төрлийн стипендийг ОХУ-ын хууль тогтоомжоор тогтоосон стипендийн фонд

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

болон стипендийн хэмжээг харгалзан бүх төрлийн категорийн суралцагчдад олгоно. */Федеральным законом от 15.07.2008 N 119-ФЗ “О внесении изменений в статью 3 Закона Российской Федерации “О минимальном размере оплаты труда” и статью 16 Федерального закона “О высшем и послевузовском профессиональном образовании” с 01.09.2008/*

Стипендийн фондыг Боловсролын байгууллагын дүрэмд заасны дагуу Эрдмийн зөвлөл хуваарилах бөгөөд ингэхдээ Оюутны үйлдвэрчний зөвлөл болон оюутны төлөөллийн оролцоотойгоор хуваарилна. Оюутны улсын стипендийг зөвхөн “онц”, “онц-сайн”, эсвэл “сайн” сурсан оюутнуудад олгоно. Энэ төрлийн стипендийг Стипендийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн ИДС-ийн захирлын тушаалаар олгоно. ИДС-ийн өдрийн ангид сурдаг оюутан-1100 руб, анхан болон дунд шатны мэргэжлийн боловсролын сургуулийн оюутан-400 руб–ийн стипенд авдаг. Мөн өдрийн ангид сурдаг дараахь төрлийн оюутнуудад 50% хүртэл нэмэгдүүлсэн стипенд олгодог. Үүнд:

- 1 болон 2-р группийн инвалид
- өнчин оюутан
- эцэг, эхийн асран хамгаалалтгүй оюутан
- 3-аас доошгүй жил эцэг, эх нь цэргийн албанд дайчлагдсан, дайны үүрэг гүйцэтгэсэн, гэрээт цэргийн алба хаасан, төрийн өмнөөс цэргийн үүрэгт ажилд дайлчагдсан, цэргийн албаны хугацаа нь дууссан ч эмнэлгийн дүгнэлтээр цэргийн албанд тэнцэхээ больсон гэх мэтийн шалтгаантай гэр бүлийн оюутан хүүхдүүд */в п. 3 ст. 51 Федерального закона от 28.03.1998 N 53-ФЗ “О воинской обязанности и военной службе”*/.

**<u>Нэрийн стипенд</u>**

ОХУ-ын улсын ИДС, анхан болон дунд мэргэжлийн боловсролын сургуулийн оюутан, аспирант, докторантуудад олгох энэ төрлийн стипендийг тогтоох, олгох журмыг тухайн стипендийг олгох төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллага, хуулийн этгээд болон хувь хүмүүс тогтооно.

**<u>Улсын халамжийн стипенд</u>**

Дараахь оюутнуудад улсын халамжийн стипенд олгоно. Үүнд:

- ✓ Өнчин хүүхдүүд болон , асран халамжлах хүнгүй хүүхдүүд
- ✓ 1, 2 -р группийн инвалид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд
- ✓ Чернобылийн АЦС-ийн аваар болон бусад радио идэвхит хордлого, гамшигт өртсөн хүүхдүүд
- ✓ Дайны ажиллагаанд оролцсон болон дайны ажиллагаанаас тахир дутуу болсон хүүхдүүд. Энэ төрлийн стипендийг энэ зорилгоор төсөвлөгдсөн стипендийн фондоос тухайн Стипендийн комиссийн саналыг үндэслэн олгоно. Стипенд авагч оюутан улсын нийгмийн халамжид хамрагдахын тулд оршин суугаа газрынхаа нийгмийн халамжийн газраас тухайн сургуульдаа тодорхойлолт авч өгнө.
- ✓ Энэхүү справкийг жил тутам олгоно. Хэрвээ суралцагч шалгалтын өртэй бол стипендийг түр түдгэлзүүлэх ба шалгалтын өргүй болсон тохиолдолд стипенд зогссон үеэс нь үргэлжлүүлэн олгоно. Дараахь тохиолдолд энэ төрлийн стипендийг олгохгүй. Үүнд:
- ✓ Оюутан сургуулиас хасагдсан

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- ✓ Стипенд олгож байсан үндэслэл үгүй болсон

Нийгмийн халамжийн стипенд авч байсан оюутан энэ төрлийн стипенд авах үндэслэл нь үгүй болсон бол бусад оюутны нэгэн адилаар ердийн журмаар академик стипендэд хамрагдах эрхтэй. Нийгмийн халамжийн стипендийн хэмжээг боловсролын байгууллага бие дааж тогтоох бөгөөд тухайн шатны боловсрлын байгууллагын хуулиар тогтоосон стипендийн тогтоосон хэмжээнээс 1/3-ээс  бага байж болохгүй. /1,5 дахин бага /

**Холбооны улсын төрийн мэргэжлийн бага боловсролын байгууллагад суралцагчдын улсын стипенд**

Энэ төрлийн стипендийг тухайн боловсролын байгууллагын удирдлагын шийдвэрээр олгоно. Стипендийг сар бүр олгоно. Семестрийн дүнгээр шалгалтын өртэй гарсан бол стипендийг түр зогсоож шалгалтын өр дууссаны дараа стипенд зогсоон өдрөөс эхлэн стипенд тооцож олгоно. Сургуулиас хасагдсан тохиолдолд дараа сараас эхлэн стипендийг зогсооно. Стипендийн хэмээг сургуулийн удирлашга бие даан тогтоох бөгөөд хуулиар тогтоосон хэмжээнээс багагүй байна.

**Цэргийн сургуулийн сонсогч болон цэргийн албанд дайлагдсан иргэний оюутан хүүхдэд улсаас олгох стипенд**

Энэ төрлийн стипендийг сонсогчид болон цэргийн албанд дайчлагсан гэр бүлийн оюутан хүүхдүүдэд сар бүр олгох бөгөөд мөн дээр дурьдсан стипендийн зарчмын дагуу олгоно.

**Суралцагсдад үзүүлдэг бусад төрлийн материаллаг дэмжлэг**

ОХУ-ын хууль, журамд заасснаар анхан, дунд, дээд мэргэжлийн боловсролын Холбооны улсын сургуульд өдрөөр суралцагсдад Стипендийн фондын 25%-тай тэнцэх хэмжээний нэмэлт эх үүсвэрийг Холбооны улсын төсвөөс гаргаж дэмжлэг үзүүлдэг. Энэхүү хөрөнгийг дараахь чиглэлээр зарцуулна. Үүнд:

- ✓ Материаллаг тусламж. Материаллаг тусламж хүссэн суралцагчийн учир шалтгаанаа тодорхойлсон хувийн өргөдлийг үндэслэн Сургуулийн удирдлагын шийдвэрээр олгоно.
- ✓ Жил тутмын шинжлэх ухааны сэтгүүл худалдан авахад үзүүлэх тусламж. Энэ төрлийн тусламжийг аспирант, докторантуудад 2 сарын стипендийн хэмжээтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
- ✓ Жилийн сургалтын материал болон бичгийн хэрэгсэл худалдан авахад зориулсан тусламж. 3 сарын стипендийн хэмжээгээр өдрийн ангид суралцдаг өнчин болон асран хамгаалах гэр бүлгүй хүүхдэд олгоно.
- ✓ Мөн түүнчлэн төсвийн нэмэлт эх үүсвэрээс соёл олон түмний ажил, биеийн тамир, эрүүлжүүлэх арга хэмжээ, амралт болон аялал, рашаан сувиалалын зардал зэргийг гаргаж болно. Энэ зориулалтаар академик стипендийг 2 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр зардал гаргаж болно.
- ✓ Өдрийн ангид сурдаг аспирант болон докторантууд 1 сараас дээш хугацаагаар өвчилсөн тохиолдолд эмнэлгийн магадлагааг үндэслэн суралцах хугацааг сунгах ба стипендийг тогтоосон хэмжээгээр олгоно.
- ✓ Мөн /*В статье 16 Федерального закона N 125-ФЗ*(3)-д*/ заасснаар ИДС-ийн оюутны нийгмийн чиглэлийн дэмжлэгт хамаарах дараахь асуудлуудыг шийдвэрлэнэ. Үүнд: улсын болон орон нутгийн номын сангийн үйлчилгээ, музей үзэх зэрэгт үнэ төлбөргүй хамрагдах

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- ✓ Мөн / *Постановлением Правительства РФ от 03.11.1994 N 1206 “Об утверждении Порядка назначения и выплаты ежемесячных компенсационных выплат отдельным категориям граждан”*/ эрүүл мэндийн шалтгаанаар академик чөлөө авсан оюутнуудад 50 руб. хүртэл хэмжээгээр нөхөн олговор олгоно. Үүнд :
- ✓ Дээд мэргэжлийн сургуулийн оюутнууд
- ✓ Дунд мэргэжлийн сургуулийн суралцагсад
- ✓ ДМС болон эрдэм шинжилгээний байгууллагад ажлаас хөндийрөн суралцаж байгаа аспирантууд хамрагдана.

Суралцагсад сурч буй сургуульдаа академк чөлөө авах тухай эрүүл мэндийн дүгнэлтийг хавсарган нөхөн олговор хүссэн өргөдөл гаргана. Тухайн сургуулийн захирал 10 хоногийн дотор шийдвэр гаргана. Олгох боломжгүй тохиолдолд шийдвэр гарсанаас хойш 5 хоногийн дотор шалтгааны талаар хариу өгнө.

Хэрвээ оюутан эрүүл мэндийн шалтгаанаар академик чөлөө авсан бол стипенд олгох уу?
**Академик чөлөө** гэдэг бол тухайн оюутан эрүүл мэндийн шалтгаанаар болон гэр бүлийн шалтгаанаар авсан чөлөө бөгөөд үргэлжлэх хугацаа нь 12 сараас дээшгүй байна.
Өнчин болон асран хамгаалах гэр бүлгүй оюутан академик чөлөө авсан бол чөлөөтэй байх хугацаанд нь улсын зүгээс үзүүлдэг дэмжлэг бүрэн хадгалагдах ба стипенд олгоно. Бусад төрлийн оюутнуудад зөвхөн нөхөн олговор олгоно.

ОХУ-ын Татварын тухай хуулиар оюутан, аспирант, докторантуудад олгосон стипенд болон бусад тэтгэлэг нь татвараас чөлөөлөгдөнө.

**ЯПОН УЛСЫН ТУРШЛАГА**

**Боловсролын салбарт оюутанд үзүүлдэг санхүүгийн дэмжлэг, тогтолцоо түүний эрх зүйн үндэслэл:**

Боловсролын ерөнхий хуулиар /Kyouiku kihon hou/ Японы боловсролын тогтолцооны стандартуудыг тогтоосон байдаг бөгөөд энэ хууль нь 1946 онд батлагдаж, 2006 онд шинэчлэгдсэн байна. Тус хуульд зааснаар тэтгэлгийн зээлийн хөтөлбөрүүд нь боловсролыг дэмжих, хүний нөөцийн хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх чухал арга хэмжээ гэж тооцогддог. Тэтгэлгийн зээлийн хөтөлбөрийг хэд хэдэн захиргааны байгууллагууд бие даан хэрэгжүүлдэг. Тухайлбал, Японы Оюутны Үйлчилгээний байгууллага (Japan Student Services Organization), орон нутгийн захиргаа, төрийн бус байгууллагуудын нэгдсэн холбоод, сургуулиуд зэрэг байгууллагууд байна.

Японы Оюутны Үйлчилгээний байгууллага 2007 онд бага хүүтэй эсхүл хүүгүй зээлүүдийг санхүүгийн хувьд боломжгүй, түүнчлэн онцгой сурлагатай оюутнуудад олгосон байх ба нийт 850,3 тэрбум иений төсвийг зарцуулсан бөгөөд 1,143,000 оюутныг хамарсан байдаг. Энэ нь Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны нийт төсвийн 2,3 хувийг эзэлсэн бөгөөд нийт 122,4 иенийг тэтгэлгийн хөтөлбөрт зарцуулсан байна.

**Тэтгэлгийн зээлийн Төсөв**

| Хөтөлбөрийн нийт зардал /тэрбум.иен/ | | 1.005 |
|---|---|---|
| Хүүгүй зээл /254.9/ | Засгийн газрын зээл | 70.3 |
| | Зээлийн эргэн төлөлт | 184.6 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| Бага хүүтэй зээл /750.6/ | Төсвийн зээлийн сан | 724.0 |
| | Төсвийн хөрөнгө оруулалт зээлийн хөтөлбөрийн байгууллагуудын өрийн бичиг | 160.0 |
| | Хувийн сангуудын зээл | 378.9 |
| | Зээлийн эргэн төлөлт | 246.7 |
| | Төсвийн зээлийн санд хийгдсэн нөхөн төлбөр | 759.0 |

*Зээлд хамрагдагсадыг сонгон шалгаруулах аргачлал:*

Сургуулийн удирдлагаас санал болгосон өргөдөл гаргагчдын материалыг хянан үзэж шийдвэр гаргана. Сонгох шалгуур нь:

- оюутны зан төлөв,
- эрүүл мэндийн байдал,
- сурлагын чадвар,
- гэр бүлийн санхүүгийн нөхцөл байдал зэргийг харгалзах болно.

Өргөдлийг сургуулиар дамжуулан Японы Оюутны үйлчилгээний байгууллага /JASSO/-д гаргана. Өргөдөл гаргагч нь гэр бүлийн санхүүгийн байдалд өөрчлөлт орсон буюу санхүүгийн гол эх үүсвэр ологч буюу тэжээн тэтгэгч нь ажилгүй болсон, дампуурсан эсхүл байгалийн гамшгаас болж санхүүгийн хүнд байдалд орсон зэрэг тохиолдолд өргөдөл гаргах боломжтой болно.

**Хүүгүй зээл:** Сургуулийн төрөл, хэлбэр, сургалтын хөтөлбөрийн төрөл, голч дүнгийн хэмжээ бүрээр ангилан гэр бүлийн орлогын хэмжээнд тохируулан олгох зээлийн хэмжээг стандартад оруулсан байдаг. Тухайлбал, Улсын сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцдаг, голч дүн нь 3,5 аас дээш байгаа оюутанд гэр бүлийн санхүүгийн байдлыг харгалзан сар бүр 30000-120000 иений зээлийг олгоно.

**Бага хүүтэй зээл:** Бага хүүтэй зээлийг дээрхийн адил ангиллаар тогтоох боловч голч дүнг бус нийт оюутнуудын дунджаас дээгүүр, эсхүл онцгой сайн гэсэн үзүүлэлтийг шалгуур болгоно. Суралцаж байх хугацаанд зээлийн хүү тооцохгүй бөгөөд төгссөний дараа жилийн 3%иас хэтрэхгүй хэмжээний хүү төлнө.

**Зээлийн эргэн төлөлттэй холбогдох асуудлууд:** Байгалийн гамшиг зэрэг зайлшгүй нөхцөл байдлын улмаас зээлээ эргэн төлөх боломжгүй болсон эсхүл сургуульдаа үргэлжлүүлэн суралцаж байгаа тохиолдолд зээлийн эргэн төлөх хугацааг сунгадаг.

**Зээл эргэн төлөх үүрэг дуусгавар болох**: Оюутан нас барсан, сэтгэл мэдрэлийн өвчтэй болсон тохиолдолд зээлийн эргэн төлөх үүрэг дуусгавар болно.

*Сургалтын төлбөрөөс чөлөөлөх:* Дээр дурдсан зээл, тэтгэлгээс гадна улсын сургуулиудад сургалтын төлбөрөөс бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөх арга хэлбэрээр санхүүгийн хүндрэлтэй, суралцах өндөр чадвартай оюутнуудыг дэмжих тогтолцоо байдаг.

**ШВЕД УЛСЫН ТУРШЛАГА**

Швед улс нь боловсролын системийн хувьд өөрийн болон гадаадын иргэдэд бүх шатны

UIH.MN СУДАЛГААНЫ САН

боловсролыг үнэ төлбөргүй олгодог өгөөмөр улс юм. 1990 оныг хүртэл, цөөхөн хэдэн бие даасан сургуулиуд байсан бөгөөд оюутны байрны төлбөрийг төрөөс санхүүжүүлдэг байсан. 1992 онд Засгийн газраас боловсролын системийн шинэчлэл хийж бүх оюутнуудийн зардлыг төрөөс бүрэн санхүүжүүлэх болсон байна. Сүүлийн үед гадаадын оюутнуудыг төлбөртэй суралцдаг болгох талаар ярилцаж байгаа.

Шведийн боловсролын салбар дахь төрийн дэмжлэгийг **Дээд боловсролын үндэсний агентлаг** хариуцан ажиллах бөгөөл тус байгууллага нь Засгийн газрын агентлаг бөгөөд дээд боловсролын хөгжил дэвшил, чанарын үнэлгээ, багшлах арга барилыг шинэчлэх асуудал болон академик зэрэг олгох шийдвэрийг үнэлэх зэрэг дээд боловсролын салбарын үйл ажиллагаанд хяналт тавих, эдийн засгийн дэмжлэг үзүүлэх ажлын хариуцдаг.

*Дээд боловсролын систем* нь дараах 3 түвшинд хуваагддаг.

- ✓ Суурь түвшин /basic level/
- ✓ Дээд *түвш*ин /Advanced level/
- ✓ Магистр, докторын түвшин /graduate level/

Суурь түвшинд:

- ✓ Дипломын түвшин- 2 жил, 120 кредит
- ✓ Баклаврын зэрэг-3 жил, 180 кредит

Дээд түвшинд:

- ✓ Магистрийн зэрэг-1 жил, 60 кр
- ✓ Магистрийн зэрэг-1 жил, 120 кр

Магистр, докторын түвшинд:

- ✓ Дипломтой мэргэжилтэн- 2 жил, 120 кр
- ✓ Докторын зэрэг /Ph.D/-4 жил, 240 кр суралцсанаар эдгээр зэргийг авдаг байна.

Шведийн дээд боловсрол нь мэргэжлийн /professional/ болон хууль, эмнэлэг, инженер гэх мэт мэргэшлийн /vocational degree/ зэрэгт хуваагддаг.

*Шведийн боловсролын хууль тогтоомж нь:*

- ✓ Дээд боловсролын хууль /higher education act/-Парламентаас батлан гаргадаг.
- ✓ Дээд боловсролын журам/higher education ordinance/-Засгийн газраас гаргаж, хяналт тавьдаг.
- ✓ Оюутны дэмжлэгийн тухай хууль /study support act/-1999:1395
- ✓ Оюутны тэтгэмжийн хууль/Study support ordinance/2000:655

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Шведийн сургалтын дэмжлэгийн систем:**

Шведийн сургалтын дэмжлэгийн систем нь Засгийн газрын зүгээс боловсролын салбарт хэрэгжүүлж буй бодлогын олон жилийн уламжлалтай үүсэлтэй. Сургалтын дэмжлэгийн систем нь Шведийн нийгмийн халамжийн системийн чухал хэсэг байдаг. Сургалтын дэмжлэг нь суралцах хугацааны турш оюутны амьдрах зардлыг санхүүжүүлдэг.
Шведийн одоогийн сургалтын дэмжлэгийн системийг 2001 оны 7 сарын 1-д танилцуулсан ба **тэтгэмж** болон **зээл**ээс бүрддэг.

*Шведийн сургалтын тэтгэмжийн систем нь:*

- ✓ *Хүн бүрт тэгш олгох,*
- ✓ *Бүх хүмүүс оролцох эрхтэй*
- ✓ *Оюутануудад шууд олгогддог*
- ✓ *Аав ээж, гэр бүлийн санхүүгийн байдлаас хараат бус бие даан олгогддог* онцлогтой.

**Сургалтын тэтгэмж** нь суралцах хугацааны турш авах сургалтын зээл болон тэтгэлгээс бүрддэг. Энэ нь хичээлийн жил бүр 40 долоо хоног олгогддог. 2007 оны байдлаар сургалтын тэтгэмжийг 950,000 оюутанд 20 тэрбум швед крон буюу 2,25 тэрбум еврогийн тэтгэмжийг олгосон байна.

Мөн суралцах хугацаа болон оюутны настай холбогдуулан сургалтын тэтгэлгийн зарим хязгаарлалт байдаг. Сургалтын тэтгэлгийг нийгмийн салбарын ерөнхий хөгжлийн дагуу жил бүр тогтоох ба бүх оюутан тэгш эрхтэй байдаг. Хүүхэдтэй оюутнууд нэмэлт тэтгэлэг авч болно.
Бүтэн цагийн /full time/ оюутан бүр 12 семистрийн хугацаанд 7 хоног бүр 1841 швед кронийн зээл болон тэтгэлгийг авах эрхтэй. Энэ нь 200 евро, 274 доллар, 127 GBP гэсэн үг юм. /*2007 оны 7 сарын байдлаар*/ Түүнчлэн оюутнууд амралтын хугацаандаа 7 хоног бүр 632 швед кронийн тэтгэлэг авдаг.




**Сургалтын зээлийн** хувьд сургалтын тэтгэмжийн нийт дүнгийн 2/3 дотор байна. Сургалтын зээлийг нийт оюутнуудын 2/3-оос илүү нь авч болно. Энэ нь оюутнуудад сургалттай холбоотой бусад нэмэлт зээл болон нэмэлт зардлын зээл авах боломжийг бий болгодог. Сургалтын тэтгэмжийн систем нь сургалтын зээлийн эргэн төлөлтөнд суурилдаг. Эргэн төлөлт нь суралцаж төгссөний дараа жилээс эхлэх бөгөөд 25 жилийн хугацаанд төлдөг. Шведийн тэтгэмжийн системийг "***Оюутны тэтгэмжийн үндэсний хороо***" голчлон удирдан зохион байгуулдаг. Сургалтын тэтгэмжийн акт болон сургалтын тэтгэмжийн хуулиар зохицуулдаг. Гадаадын болон швед оюутнууд нь суралцах хугацаанд нэмэлт тэтгэлэг авч болно.

Швед улс нь нийгмийн хамгааллын салбарт зарцуулдаг мөнгөний хэмжээгээрээ Европт нилээд дээгүүр байр эзэлдэг бөгөөд ДНБ-нийхээ 4,9 хувийг энэ салбарт зарцуулдаг байна. 2011 оны Шведийн засгийн газраас боловсруулсан төсөвт оюутны санхүүгийн дэмжлэгт 2009 онд 21,4 тэрбум швед крон, 2010 онд 23,1 тэрбум швед крон төсөвлөсөн бөгөөд 2011 онд 23,5 тэрбум швед крон зарцуулахаар төсөвлөсөн байна. Мөн академик судалгаа болон боловсролд 2009 онд 48,8 тэрбум швед крон, 2010 онд 53,0 тэрбум швед крон, 2011 онд 54,5 тэрбум швед кронийг төсөвлөсөн байна.

**Швед улсын боловсролын салбар дахь төрөөс үзүүлж дэмжлэгийн зохицуулалт**

| | |
|---|---|
| **Эрх зүйн актууд** | -Дээд боловсролын хууль /higher education act/<br>-Дээд боловсролын журам/higher education ordinance/-Засгийн газраас гаргаж, хяналт тавьдаг<br>-Оюутны тэтгэмжийн хууль /study support act/-1999:1395<br>-Оюутны тэтгэмжийн журам /Study support ordinance/2000:655 |
| **Төрийн дэмжлэгийн хэлбэр** | ✓ Тэтгэлэг<br>✓ Зээл |
| **Зээлийг эргэн төлөх журам** | Сургуулиа төгссөний дараа жилээс эхлэн 25 жилийн хугацаанд төлдөг. |
| **Хариуцан хэрэгжүүлэх байгууллага** | -Дээд боловсролыг үндэсний агентлаг,<br>-Оюутны тэтгэмжийн үндэсний хороо хэрэгжүүлдэг.<br>-Боловсрол, судалгааны яам хяналт тавьдаг. |

**ТУРК УЛСЫН ТУРШЛАГА**

Бүгд Найрамдах Турк улсад төрийн их дээд сургуулиудын боловсролын үйлчилгээг олон нийтийн үйлчилгээнд (Public service) хамруулан авч үздэг бөгөөд нэг оюутанд ногдох боловсролын зардлын дийлэнх хувийг төрөөс даадаг байна. Харин оюутнууд бага хэмжээний төлбөрийг өөрсдийн сургалтад оруулах нэмэр нэрийн доор төлдөг байна.
**Эрх зүйн үндэслэл**: Турк улсын төрөөс боловсролын салбарт үзүүлж байгаа аливаа дэмжлэгийг “Дээд боловсролын зээл, дотуур байрны удирдах газрын тухай”, “Дээд боловсролын тухай”, “Үндэсний боловсролын тухай” хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад журмаар зохицуулдаг байна.

Дээрх хууль тогтоомжуудаар зохицуулсан оюутны дэмжлэг тусламжийг дараахь хэлбэрээр ангилж болно.

**Оюутны дэмжлэг тусламжийн төрлүүд**:

- ✓ Зээл
- ✓ Буцалтгүй тусламж, тэтгэлэг
- ✓ Бусад дэмжлэг туслалцаа гэсэн үндсэн төрлөөс бүрдэнэ. Үүнийг схемчлэн үзүүлбэл:




UIH.MN СУДАЛГААНЫ САН

**а) Зээл**

**1.** ***Эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл*** буюу Сургалтын зээл **( loan):** Эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл буюу Сургалтын зээл нь тухайн оюутныг **сурах явцад шаардагдах аливаа зардлыг санхүүжүүлэх зээл** ба хуульд заасан тодорхой журмын дагуу эргэн төлөгдөх бөгөөд, гадаадад болон дотоодод их дээд сургуульд суралцах болзол хангасан сурагчдын санхүүгийн хэрэгцээ, шаардлага сурлагын байдлыг харгалзан сар бүр олгоно.

*Хүү:* Сургалтын зээл нь хүүгүй байх бөгөөд зээлд хамрагдсан хугацааны инфляцийг нэмэн тооцоолж эргэн төлнө.

*Хугацаа:* Тухайн оюутан сурч байх хугацаанд олгоно. Сургуулиас ямарваа нэгэн байдлаар хасагдсан, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн тохиолдолд зээлийг цуцлана.

*Эргэн төлөлт:* Бакалаврын зэргийн сургалтанд хамрагдсан тохиолдолд их дээд сургууль төгссөнөөс хойш 2 жилийн дараа, магистрын сургалтад хамрагдсан бол 3 жилийн дараа, сургуулиас хасагдсан, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн бол 1 жилийн дараанаас эхлэн зээлийг төлнө.

***Дараахь нөхцлүүдэд сургалтын зээлд хамрагдахгүй*:**

1. Төрөөс ямар нэгэн тэтгэлэг авдаг бол,
2. Цалингийн доод хэмжээ болон түүнээс дээш тогтмол цалинтай ажилд ажилладаг тохиолдолд,
3. Урьд нь их дээд сургууль төгссөн бол (магистрантур, докторантураас бусад)
4. Эрүүл мэндийн шалтгаанаас бусад шалтгаанаар чөлөө аван, бэлтгэл ангид суралцаж буй сурагчид
5. Магистр, докторын бэлтгэл ангид суралцаж буй сурагчдад
6. Зээлд бүртгүүлэх үедээ хамгийн багадаа нэг жил улиран суралцсан бол
7. Өмнө нь сургалтын зээл авсан сурагчид (магистрантур, докторантураас бусад)
8. Сурч буй сургууль болон амьдарч буй дотуур байрандаа ганцаараа болон группээрээ анархи болон терроризмын үйл ажиллагаанд оролцсон, бусдын суралцах эрхийг хааж боогдуулах, эсэргүүцэл, хориг, эзлэн түрэмгийлэл гэх зэрэг үйлдэл хийсэн, хийхээр оролдсон, биеэс нь болон амьдарч буй газраас нь галт зэвсэг, тэсрэх дэлбэрэх бодис, хутга шөвөг гэх мэт бүх төрлийн зэвсэг, дайрах болон бие хамгаалахад хэрэглэгдэх зориулалт бүхий гэмт хэргийн хэрэгсэл олдсон сурагчид
9. Суралцаж буй сургуулийнхаа дотоод дэг журмыг зөрчсөний улмаас сургуулийн захиргаанаас шийтгэл хүлээлгэсэн бол
10. Хуурамч бичиг баримт бүрдүүлсэн бол
11. Гадаадын суралцагсад
12. Уг журмын дагуу зээл авах шаардлага байхгүй гэж үзсэн сурагчдад зээл олгохгүй ба үүнээс бусад тохиолдолд зээл олгоно.

Сургалтын зээлийг 1961 оны “*Их дээд боловсролын зээл, дотуур байрны удирдах*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*газрын тухай*" 351 тоот хууль болон уг хуулийн 14-р зүйлд нийцүүлэн баталсан журмаар зохицуулсан байна.

**2. *Хувь нэмрийн зээл* (Contribution loan*):*** Энэ нь дотоодын их дээд сургуульд элсэн суралцаж буй оюутны сургалтын **төлбөрийг төрөөс төлөх хэлбэрээр олгогддог зээл** юм. Тухайн оюутны санхүүгийн хэрэгцээ шаардлага, ар гэрийн амьдрал, их дээд сургуульд элссэн элсэлтийн шалгалтын дүн, эхний жилийн сурлагын дүнгийн үзүүлэлт зэргийг харгалзан олгодог байна.

> *Зээлийн хүү:* Хувь нэмрийн зээл нь хүүгүй байх бөгөөд зээлд хамрагдсан хугацааны инфляцийг нэмэн тооцоолж эргэн төлнө.
> *Зээлийн хугацаа:* Тухайн оюутан сургуульд сурч байх хугацаанд олгох ба сургуулиас ямарваа нэгэн байдлаар хасагдсан, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн тохиолдолд тухайн зээл цуцлагдана.
>
> *Зээлийн эргэн төлөлт:* Бакалаврын зэргийн сургалтад хамрагдсан тохиолдолд их дээд сургуулиа төгссөнөөс 2 жилийн дараа, магистрын сургалтад хамрагдсан бол 3 жилийн дараа, сургуулиас хасагдсан, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн бол 1 жилийн дараанаас эхлэн тухайн зээлийг эргүүлэн төлнө.

***Дараахь нөхцлүүдэд хувь нэмрийн зээлд хамрагдахгүй:***

1. Цалингийн доод хэмжээ болон түүнээс дээш тогтмол цалинтай ажилд ажилладаг
2. Урьд нь их дээд сургууль төгссөн бол (магистрантур, докторантураас бусад)
3. Эрүүл мэндийн шалтгаанаас бусад шалтгаанаар чөлөө аван, бэлтгэл ангид суралцаж буй бол
4. Магистр, докторын бэлтгэл ангид суралцаж буй бол
5. Зээлд бүртгүүлэх үедээ хамгийн багадаа нэг жил улиран суралцсан бол
6. Өмнө нь хувь нэмрийн зээл авсан оюутнууд (магистрантур, докторантураас бусад)
7. Сурч буй сургууль болон амьдарч буй дотуур байрандаа ганцаараа болон группээрээ анархи болон терроризмын үйл ажиллагаанд оролцсон, бусдын суралцах эрхийг хааж боогдуулах, эсэргүүцэл, хориг, эзлэн түрэмгийлэл гэх зэрэг үйлдэл хийсэн, хийхээр оролдсон, биеэс нь болон амьдарч буй газраас нь галт зэвсэг, тэсрэх дэлбэрэх бодис, хутга шөвөг гэх мэт бүх төрлийн зэвсэг, дайрах болон бие хамгаалахад хэрэглэгдэх зориулалт бүхий гэмт хэргийн хэрэгсэл олдсон оюутнууд
8. Хуурамч бичиг баримт бүрдүүлсэн бол
9. Гадаадын оюутнууд
10. Уг журмын дагуу зээл авах шаардлага байхгүй гэж үзсэн оюутнууд
11. Сургуулиа хугацаанд нь төгсөөгүй улиран суралцаж буй бол
12. Эчнээ ангид суралцаж буй бол
13. Магистр, докторын сургалтанд хамрагдаж байгаа бол
14. Төсвөөс санхүүждэггүй буюу хувийн их дээд сургуулиудад сурдаг бол хамрагдахгүй.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хувь нэмрийн зээлийг "*Их дээд боловсролын тухай*" 2547 тоот хууль болон уг хуулийн 46-р зүйлд нийцүүлэн баталсан "*Хувь нэмрийн зээлийн тухай*" журмаар тус тус зохицуулсан байна.

**b) Буцалтгүй тусламж, тэтгэлгүүд (grant)**

Туркийн төрөөс боловсролын салбарт үзүүлж дэмжлэгийн нэг хэлбэр болох тэтгэлэг нь оюутанд сар бүр тогтсон хэмжээгээр олгогдох бөгөөд дараахь 2 төрөлтэй байна.




***Үндэсний Боловсролын Яамны тэтгэлэг:*** Уг тэтгэлэг нь Боловсролын яамны сонгон шалгаруулалтаар гадаад орнуудад улсын зардлаар сурах болзол хангасан оюутнуудад олгох буцалтгүй тусламж юм. Энэ нь БНТУ-ын Засгийн газрын болон бусад улсын засгийн газруудтай хийсэн гэрээний дагуу тухайн улсын Засгийн газрын тэтгэлгээр болон Турк улсын Засгийн газрын тэтгэлгээр гэсэн 2 хэлбэртэй байна.

**Тэтгэлгийг олгох үндэслэл:**

- сонгон шалгаруулалтад тэнцсэн байдал,
- сурлагын дүн,
- эрдэм шинжилгээний амжилт зэргийг харгалзан олгоно.

**Тэтгэлгийн хэмжээ нь** бакалавр, магистр болон докторын түвшинд өөр өөр байна. Жилийн эхэнд тогтоосон хэмжээгээр сар бүр олгодог бөгөөд харин дараа жилийн эцэст хэрэглээний үнийн индексийг тэтгэлгийн хэмжээнд тусган тэтгэлгийн хэмжээг жил бүр шинэчлэн батлана.

Энэхүү тэтгэлгийг "Үндэсний боловсролын хууль" болон дээрх хуульд нийцүүлэн баталсан тэтгэлэг олгох тухай журмаар зохицуулсан байна.

***Засгийн газрын тэтгэлэг:*** БНТУ-ын Засгийн газрын зүгээс их дээд сургуулийн оюутнуудад олгодог буцалтгүй тусламжийн хэлбэртэй тэтгэлэг юм. Уг тусламжинд хамрагдахад тухайн оюутны санхүүгийн хэрэгцээ, ар гэрийн амжиргааны түвшин, сурлагын амжилт зэргийг харгалзан үзнэ.

Тус тэтгэлэгийг жилийн эхэнд тогтоогдсон хэмжээгээр сар бүр тогтмол олгоно. Жил бүр хэрэглээний үнийн индексээр тэтгэлгийн хэмжээг дахин баталдаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Тэтгэлэгт хамрагдах үндэслэл:**

- Ар гэрийнхээ сарын орлогыг тодорхойлж, санхүүгийн тусламж авах шаардлагатай болохоо батлах хэрэгтэй.
- 1-р дамжааны оюутнуудын сурлагын амжилтыг харгалзалгүй олгох бөгөөд 2-р дамжаанаас эхлэн тухайн оюутны сурлагын амжилтыг харгалзан олгоно. Хэрэв тэтгэлэгт хамрагдсан сурагч нэг улиралд 4-өөс дээш хичээл дээр амжилтгүй суралцан унасан бол тэтгэлэг олгохыг зогсооно. 3 болон 4-р дамжаанд суралцаж байхдаа доод дамжааны мэргэжлийн хичээлүүдээс хамгийн багадаа 1 хичээл дээр унасан тохиолдолд мөн тэтгэлгийг зогсооно.
- Уг тэтгэлгийг сэргээх боломжтой ба тэтгэлгээ зогсоолгох шалтгаан болсон хичээлүүдээ амжилттай дүүргэсэн дүнгийн тодорхойлолтоо авчирж дахин бүртгүүлж болдог байна.

**c) Бусад дэмжлэг, тусламжууд**

***Эрүүл мэндийн үйлчилгээ:*** Эцэг эх нь улсын аль нэг даатгалын үйлчилгээнд хамрагдсан бол эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг эцэг эхийн даатгалын хүрээнд төрөөс хариуцна.

Эцэг эх нь улсын аль нэг даатгалын үйлчилгээнд хамрагдаагүй тохиолдолд сургуульд бага хэмжээний төлбөр төлснөөр эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээний 90%-ийг төр даана.

***Ном дэвтэр, өвлийн хувцасны мөнгө:*** Боловсролын яамны тэтгэлгэд хамрагдаж буй оюутнуудад жил бүр хичээлийн жилийн эхэнд ном дэвтэрний мөнгө олгох ба өвлийн улирал эхлэх үед өвлийн хувцасны мөнгө олгодог. Эдгээр мөнгө нь сарын тэтгэлгийн хэмжээг 2-3 дахин нугалсантай тэнцэх хэмжээтэй байдаг байна.

***Оюутны дотуур байр*:** Боловсролын яамны тэтгэлгэд хамрагдаж буй оюутнуудыг дотуур байраар үнэгүй хангана.

**АНУ-ын ТУРШЛАГА**

Холбооны Засгийн газрын Оюутны Тусламжийн (Student Aid) гол зорилго нь буцалтгүй тусламж (grant) болон зээлд (loan) хамрагдах болзлыг хангаж буй бүх оюутнуудыг эдгээр санхүүгийн тусламж дэмжлэгт (Aid) хамруулах явдал юм. Эдгээр хөтөлбөрүүдээр дамжуулан АНУ-ын засгийн газраас жил бүр 83 тэрбум гаруй долларын зээл болон буцалтгүй тусламжийг 14 сая их дээд сургуульд суралцагсад болон тэдний ар гэрийнхэнд олгож байна.

Нэгдсэн Улсын Боловсролын Газрын харъяа Холбооны Засгийн газрын Оюутны Тусламжийн газраас (Federal Student Aid) оюутнуудад олгож байгаа дэмжлэгийг буцалтгүй тусламж(grants), ажиллаж-сурах болон зээл хэмээн 3 ангилж болохоор байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**Холбооны Засгийн газраас оюутнуудад үзүүлдэг тусламж дэмжлэгүүд**

| Зээл тусламж | Хэлбэр | • Хэнд<br>• Хэмжээ (жилд) |
|---|---|---|

| | | |
|---|---|---|
| Холбооны засгийн газрын Пеллийн тэтгэлэг (Сенатч Клейборн Пеллийн нэрэмжит) | • Буцалтгүй тусламж (grant)<br>• Higher Education Act 1965, Title IV, Subpart 1, Sec.401 Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.401 | • Бакалаврын оюутнуудад зориулсан. Хүсэлт гаргасан оюутнуудын санхүүгийн хэрэгцээг харгалзан олгоно.<br>• 2008–09: $400–$4,731 |
| Холбооны ЗГ-ын боловсролын нэмэлт тэтгэлэг (FSEOG) | • Буцалтгүй тусламж (grant)<br>• Higher Education Act 1965, Title IV, Subpart 3 Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.406 | • Санхүүгийн онцгой хэрэгцээ бүхий оюутнуудад зориулсан. Пеллийн тэтгэлэгт хамрагдагсад давуу эрхтэй байна. Уг тэтгэлгийг тухайн сургуулийн санхүүгийн боломжийг харгалзан олгоно.<br>• $100–$4,000 |
| Сургалт судалгааны өрсөлдөх чадварын тэтгэлэг (ACG) | • Буцалтгүй тусламж (grant)<br>• Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.402 | • Пелл тэтгэлэгт хамрагдах боломж бүхий, мэргэжлийн сертификат олгох хөтөлбөрийн 1 болон 2 дугаар дамжаанд эсвэл зэрэг олгох хөтөлбөрийн 1 дүгээр дамжаанд суралцаж байгаа, хамгийн багадаа half-time сургалтанд хамрагдагсад.<br><br>• 1-р дамжаа: Ахлах сургуулийг 2006.1.1-ээс хойш төгссөн, ахлах сургуулийн нягт хатуу хөтөлбөрийг дүүргэсэн, урьд их дээд сургуульд хамрагдаж байгаагүй.<br>• 1-р дамжаа: $750 хүртэл<br><br>• 2-р дамжаа: ахлах сургуулийн чанд хатуу сургалтанд хамрагдсан, 2005 оны 1 сарын 1-нээс хойш төгссөн, их дээд сургуулийн 1-р дамжаагаа хамгийн багадаа 3 голч дүнтэй дүүргэсэн.<br>• 2-р дамжаа: $1,300 хүртэл |
| Шинжлэх ухаан, математикийн үндэсний тэтгэлэг (National SMART Grant) | Буцалтгүй тусламж (grant) | • Пеллийн тэтгэлэгт хамрагдах боломжтой их дээд сургуулийн 3, 4 (5 жилийн хөтөлбөр бол 5) –р дамжаанд хамгийн багадаа half-time суралцдаг оюутнууд. Дүнгийн голч нь 3-аас дээш байх.<br>• Жилд $4,000 хүртэл |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| Коллеж болон Их дээд сургуулиудад Багшийн мэргэжлээр сурч буй оюутнуудад үзүүлэх тэтгэлэг (TEACH) Grant | • Нөхцөлтэй буцалтгүй тусламж (grant): Тус үйлчилгээний үүрэг шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тэтгэлэг олгогдсон өдрөөс эхлэн хүүг нөхөн тооцож, үндсэн мөнгөн дүнгийн хамт төлнө.<br>• Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.412 | • Бага болон дунд сургуулийн багш болохоор Бакалавр болон магистр докторын зэргээр сурч байгаа болон сурах гэж байгаа “Алба хаах гэрээ”-нд гарын үсэг зурсан оюутнууд. Тус гэрээнд гарын үсэг зурснаар тухайн оюутан нь сургуулиа төгссөнийхөө дараа 8 жилийн дотор шаардлагатай байгаа салбарт бага болон дунд сургуульд бүтэн 4 жил ажиллахыг зөвшөөрнө.<br>• Жилд $4,000 хүртэл |
| Холбооны ЗГ-ын ажиллах-сурах хөтөлбөр | • Сургуульд сурч байх хугацаандаа ажиллаж олсон мөнгө буцаж төлөгдөхгүй.<br>• Higher Education Act 1965, Title IV, Sec.441<br>Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.441 | • Бакалавр болон Магистр докторын оюутнууд сургууль болон сургуулиас гадуур ажиллах боломжтой бөгөөд хамгийн багадаа цалингийн доод хэмжээгээр цалинжина.<br>• Тогтсон хэмжээ байхгүй. |
| Федерал Перкинзийн зээл | • Зээл: эргэн төлөгдөнө<br>• Higher Education Act 1965, Title IV, Sec.461<br>Higher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.461 | • Бакалавр болон магистр докторын оюутнуудад зориулсан. Зээл олгосон сургуульдаа эргэн төлнө. 5 хувийн хүүтэй<br>• Бакалаврын сургалт: $5,500 хүртэл; магистр доктор боон мэргэжлийн зэрэг: $8,000 хүртэл |
| Дэмжлэгтэй Стаффордын зээл | • Зээл: эргэн төлөгдөнө | • Дэмжлэгтэй Стаффордын зээлийн хүүг Нэгдсэн Улсын Боловсролын Газар хариуцаж төлөх бөгөөд уг зээлийг хүлээн авагч нь санхүүгийн хэрэгцээгээ баталж үзүүлэх шаардлагатай. Хамгийн багадаа half-time –р их дээд сургуулийн сургалтад хамрагдах ёстой. 6 хувийн хүүтэй.<br>• Дүнгийн байдлыг харгалзан $3,500–$8,500 байна. |
| Дэмжлэггүй Стаффордын зээл | • Зээл: эргэн төлөгдөнө<br>• Higher Education Act 1965, Title IV, Sec.4286H | • Дэмжлэггүй Стаффордын зээлийн хүүг зээлдэгч өөрөө төлөх бөгөөд санхүүгийн хэрэгцээгээ заавал батлан үзүүлэх шаардлагагүй. Хамгийн багадаа half-time –р их дээд сургуулийн сургалтад хамрагдах ёстой. 6,8 хувийн хүүтэй.<br>• дүнгийн байдал болон гэр бүлийн хараат хүмүүс бий эсэхийг харгалзан $5,500–$20,500 |

UILI.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| ПЛАС зээл | • Зээл: эргэн төлөгдөнө<br>• Higher Education Act 1965, Title IV, Sec.428. BHigher Education Opportunity Act 2008, Title IV, Sec.461 | • Их дээд сургуулийн бакалавр болон магистр, докторын сургалтанд хамгийн багадаа half-time хамрагддаг, эцэг эхээсээ хараат байдаг оюутнуудын эцэг эхэд зориулсан зээл. Санхүүгийн хэрэгцээг батлах шаардлагагүй. Зээлдэгч нь урьд өмнө ямар нэгэн зээл авч байсан бол зээлийн зөрчилгүй байх. ПЛАС зээл нь дэмжлэггүй зээл бөгөөд зээлдэгч нь бүх хүүг төлнө. 8,5 хувийн хүүтэй.<br>• Дээд хэмжээ нь тухайн сургуульд суралцахад шаардлагатай, сургалт, ном, байр хоол гэх мэт бүх зардлаас оюутны авч буй бусад санхүүгийн тусламжийг хассантай тэнцүү байна. Доод хязгаар байхгүй. |

***Дээрх зээл тусламжид хамрагдахад дараахь үндсэн шалгууруудыг харгалзана.***

Үүнд:

- Санхүүгийн хэрэгцээ шаардлагаа баталж үзүүлэх (дээр хүснэгтэд дурдсан тодорхой зээлүүдээс бусад)
- Нэгдсэн Улсын иргэн байх. Хүчинтэй Нийгмийн хамгааллын дугаар бүхий байнгын оршин суугч, цагаач, дүрвэгч, зэрэг АНУ-ын харъяат бус хүмүүс
- Их дээд сургуулийн ямар нэгэн зэрэг, сертификатын хөтөлбөрт хамрагдах
- Их дээд сургуулийн боловсролд хамрагдах боломжтой болохоо доорх хэлбэрүүдийн аль нэгээр батлах
    - Дунд сургууль төгссөн гэрчилгээ эсвэл Ерөнхий Боловсролын Хөгжлийн Сертификат
    - Дунд сургуулийн диплом эсвэл ЕБХС байхгүй бол тухайн сургуульд элсэн суралцах чадвартай эсэхийг шалгах шалгалтад тэнцсэн байдал.
    - Холбооны Засгийн газрын зүгээс хүлээн зөвшөөрсөн тухайн муж улсын бусад стандартуудыг хангасан эсэх
    - Мужийн хуулийн дагуу гэрээр дунд сургуулийн боловсрол эзэмшсэн.
- Их дээд сургуульд элсэн орсныхоо дараа шаардлагатай сурлагын түвшинг хангаж чадах.

Дээрх зээл тусламжуудыг 1965 оны АНУ-ын “Дээд Боловсролын Тухай хууль” (*Higher Education Act, Title IV- Student Assistance*), 2008 оны Их Дээд Боловсролын Боломжийн тухай (*Higher Education Opportunity Act, Title IV- Student Assistance*) зэрэг хууль тогтоомжоор зохицуулсан байна.

**АНГЛИ УЛСЫН ТУРШЛАГА**

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын хувьд боловсролын салбарт үзүүлж буй төрийн дэмжлэгийг “Боловсролын тухай хууль” болон “Дээд боловсролын тухай” хууль, түүнд зохицуулан баталсан холбогдох журам, хөтөлбөрүүдээр зохицуулдаг байна.

Их Британийн хувьд төрөөс үзүүлж буй оюутны дэмжлэгийг “Английн дээд боловсролын сангийн зөвлөл” / *Higher education funding council for england*/, Английн оюутны санхүүжилтийн газар /Student Finance England/ зэрэг бие даасан байгууллагууд хариуцдаг.

IIH.MN СУДАЛГААНЫ САН

Засгийн газраас Английн оюутны санхүүгийн байгууллагаар дамжуулан тэтгэмж /grant/, зээл /loan/, сургуулиас нь олгодог тэтгэлэг /bursary/ зэрэг хэлбэрүүдээр оюутнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлдэг бөгөөд оюутан хэрэгцээтэй үедээ санхүүгийн дэмжлэг авах ба энэ мэт авсан зээлээ сургууль төгсөх хүртлээ буюу жилд J15000 орлого олдог болох хүртлээ эргүүлэн төлөхгүй байж болно.

Дээрх хууль тогтоомжид заасны дагуу Англи улсын Засгийн газраас их дээд сургуулийн оюутнуудад зориулан дараахь төрлийн дэмжлэг туслалцааг үзүүлдэг. Үүнд:

1. ***Буцалтгүй тусламж, тэтгэлэг*** /Grant/
2. ***Зээл*** /Loan/ гэсэн үндсэн хоёр төрлийн дэмжлэг хамаарна. Энэхүү дэмжлэг, тусламжийн төрөл болон хэлбэрүүдийн ангилалыг схемчлэн үзүүлбэл:




1. <u>Буцалтгүй тусламж, тэтгэлэг</u>

- ***Эргэн төлөгдөх нөхцөлгүй амьжиргааны тэтгэлэг***:

  Энэ нь сар тутам тогтоосон хэмжээгээр тогтмол олгодог тэтгэлэг юм. “Боловсролын тухай” болон “Дээд боловсролын тухай” хуулиудад зааснаар жилийн J25000-аас доош орлого бүхий айлын хүүхдүүд J2906 хүртэл тэтгэмж авах эрхтэй. Харин жилийн J50020 хүртэл орлоготой айлын хүүхдүүд хэсэгчилсэн тэтгэлэг авдаг байна. Хэрэв шинээр их дээд сургуульд элсэн орж байгаа бол тухайн оюутнуудын 40% нь бүрэн амьжиргааны тэтгэлэгт хамрагдах боломжтой байдаг байна. /*Бүрэн амьжиргааны тэтгэлэг нь оюутны суралцахад шаардагдах бүхий л амьжиргааны зардлыг санхүүжүүлэхийг хэлнэ/*

- ***Хүүхэдтэй болон тэжээн тэтгүүлэгчтэй оюутны тэтгэлэг:***

  Энэ нь суралцахыг хүсэж байгаа бөгөөд тэднээс хамааралтай асрамжлах шаардлагатай хүмүүстэй хамт амьдардаг тохиолдолд төрөөс тэдгээр оюутнуудад үзүүлдэг нэмэлт амьжиргааны тэтгэлгийг хэлнэ. Энэ төрлийн тэтгэлэг нь дараахь хэлбэртэй байна.

| Хүүхэдтэй болон бусад тэжээн тэтгүүлэгчтэй оюутны тэтгэлэг | Дээд хэмжээ |
|---|---|
| **Хүүхэдтэй оюутны тэтгэлэг** | |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | |
|---|---|
| -1 хүүхэдтэй бол | долоо хоногт J148,75 |
| -2 хүүхэдтэй бол | долоо хоногт J255 |
| **Эцэг эхийн сургалтын тэтгэмж** | жилд J1508 |
| **Насанд хүрсэн тэжээн тэтгүүлэгчтэй оюутны тэтгэлэг** /*насанд хүрсэн хүүхэд орохгүй*/ | жилд J2642 |

- ***Тахир дутуу болон хөгжлийн бэрхшээлтэй оюутны тэтгэлэг:***

Мөн дээр дурьдсан хуулиудад зааснаар хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад доорх төрлийн тэтгэлгийг дараахь хувь хэмжээтэйгээр олгоно. Үүнд:

| **Тусгай аппарат хэрэгслийн тэтгэмж** | **нэг курст J5161.** |
|---|---|
| **Эмнэлгийн бус тусламжийн тэтгэмж /** ***бүтэн болон хагас өдрөөр сурч байгаатай холбогдон өөрчлөгдөнө.*****/** | жилд J20520. |
| **Тахир дутуугийн тэтгэмж** | жилд J1724 |
| **Замын зардал:** | дээд хязгаар байхгүй. |

2. **<u>Зээл:</u>**

- ***Сургалтын төлбөрийн зээл:***

Английн Засгийн газраас дээд сургуулиудын оюутнуудын хувьд сургалтын төлбөрт нэмэрлэх зорилгоор олгодог сургалтын төлбөрийн зээл олгох харилцаа хуулиар зохицуулагдсан байх ба түүний хэмжээ нь J3290 хүртэл байна. Уг зээлийн хэмжээг оюутны ар гэрийн жилийн дундаж орлогыг харгалзан тогтоодог бөгөөд “Английн оюутны санхүүжилтийн газар” (*Student finance department of England*) тухайн сургууль руу шууд төлдөг байна.

*<u>Сургалтын төлбөрийн зээлд хамрагдахад тавигдах шаардлагууд</u>*:

- Оюутны сурч буй сургалтын хөтөлбөр нь их дээд сургуулийн зэрэг олгох, дээд сургуулийн диплом болон сертификатын, мэргэжлийн зэрэг, диплом олгох зөвшөөрөгдсөн сургалт бол
- Оюутан, түүний гэр бүлийн хүн, эцэг эхийн аль нэг нь хууль ёсоор дүрвэх болон тус улсад чөлөөтэй орж гарах зөвшөөрөл авсан бол
- Оюутан болон түүний гэр бүлийн хүн, эцэг эхийн аль нэг нь Европын Холбооны улсын харъяат бол
- Оюутан тус улсад байнга оршин суух зөвшөөрөл авсан бол
- Хуульд заасан бусад шаардлагуудыг хангасан тохиолдолд Засгийн газрын зээлд хамрагдах эрхтэй болно.

*<u>Зээлийн эргэн төлөлт:</u>* Оюутны сургалтын зээлийг дараахь хэлбэрээр эргэн төлж болно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Үүнд:

- ✓ Зээлдэгч зээлээ шууд “Ажил эрхлэлт, сургалтын хэлтэс”т төлөх
- ✓ Татварын системээр дамжуулан төлөх
- ✓ Ажил олгогч цалингаас нь хасах хэлбэрээр гэсэн үндсэн 3 хэлбэрээр төлнө.

“**Ажил эрхлэлт, сургалтын хэлтэс**” нь Их Британийн Боловсролын яамны харъяа газар бөгөөд их, дээд сургууль төгсөгчдийн ажил, эрхлэлт, сургалт болон түүнтэй холбоотой бусад асуудлыг хариуцах ба нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлнэ.

Гадаадын зээлдэгч нар нь 3 сараас илүү хугацаагаар Их Британиас гарах тохиолдолд “Ажил эрхлэлт, сургалтын хэлтэс”-д мэдэгдэх үүрэгтэй бөгөөд сар бүрийн тогтсон өдөр төлбөрийн төлөвлөгөөний дагуу зээлийг эргэн төлнө. Хэрэв зээлдэгчийг тогтсон төлөвлөгөөний дагуу зээлээ тогтмол төлж байна гэж үзвэл “Ажил эрхлэлт, сургалтын хэлтэс” нь орлогын дагуу төлөхийг зөвшөөрдөг. Зээлдэгч төлбөр хийх хугацаанаас хойш 12 сарын цалингийнхаа нийлбэрийн 9%-тай тэнцэх мөнгийг 12 хуваaж төлнө.

- ***Эргэн төлөгдөх нөхцөлтэй амьжиргааны зээл:***

Оюутны хоол байрны мөнгө, сургалтын материалын төлбөр зэрэг сургалтын бусад зардлыг төлөхөд зориулсан зээл юм. Уг зээлийн хэмжээ нь хаана сурч байгаа болон өөр эрх бүхий байгууллагаас амьжиргааны тэтгэлэг авсан эсэх, оюутны өөрийн болон ар гэрийн орлогын хэмжээнээс хамаарна. Эцэг эхээсээ хол Лондон хотод сурч байгаа бол жилийн J6928, эцэг эхээс хол, Лондонгоос бусад хотод сурч байгаа бол J4950, сурах хугацаандаа эцэг эхийн хамт амьдарч байгаа бол жилд J3838 гэх мэт харилцан адилгүй хэмжээтэй байна.

*Дээрх тэтгэлэг болон зээлүүдэд хамрагдахад доорх ерөнхий болзлууд шаардагдана*. Үүнд:

- ➢ Нэгдсэн Вант Улсын иргэн байх, эсвэл тогтмол суурьшилтай оршин суугч байх.
- ➢ Хэвийн оршин суугч байх.
- ➢ Их дээд сургуулийн сургалт эхлэхээс 3 жилийн өмнөөс эхлэн Нэгдсэн Вант Улс, Канадын арлууд болон Менийн аралд оршин суусан байх.
- ➢ Амьжиргааны зээлд хамрагдахад 60-аас доош настай байх, /*харин Сургалтын төлбөрийн зээлд хамрагдахад насны дээд хязгаар байхгүй.*/
- ➢ Оюутны сурч буй сургалтын хөтөлбөр нь их дээд сургуулийн зэрэг олгох, дээд сургуулийн диплом болон сертификатын, мэргэжлийн зэрэг, диплом олгох зөвшөөрөгдсөн сургалт байх зэрэг ерөнхий шаардлагуудыг хангасан байх шаардлагатай. .

UIL.MN
СУДАЛГААНЫ САН

**БНХАУ-ын ТУРШЛАГА**

БНХАУ-ын дээд боловсролын салбар дахь төрийн дэмжлэг, сурлагын мөнгөн шагнал зэргийг тус улсын Сангийн яам болон Боловсролын яамнаас гаргасан баримт бичгээр зохицуулдаг байна.

**Төрийн дэмжлэгийн хэлбэр:**

Сангийн яам , боловсролын яамнаас 2007 оны 06 сарын 27-нд гаргасан “Энгийн дээд боловсролын сургууль, дээд боловсролын мэргэжил олгох сургуулиудын оюутны тэтгэлэг

удирдах түр хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний тухай мэдэгдэлд заасны дагуу “*Улсаас голдуу эдийн засгийн хувьд хүнд амьдралтай гэр бүлд амьдардаг оюутнуудад амьжиргааны зардал өгөх зорилгоор энэ* ***оюутны тэтгэлгийг*** *олгоно. Улсаас оюутны тэтгэлгийн хэмжээг дунджаар нэг оюутанд нэг жилийн 2000 юаниар тогтоодог*.” Стандартыг жил бүр нэг оюутанд 1000-3000 юаны дотор тогтоодог. Үүнийг 2-3 зэрэглэлд ангилдаг байна. Тус улсын төрөөс үзүүлж буй дэмжлэг нь:

- Тэтгэлэг
- Зээл
- Сургалтын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт
- Оюутны сургалтын мөнгөн шагнал
- Оюутныг дэмжих мөнгөн шагнал
- Оюутны халамжийн тэтгэлэг зэргээс бүрдэнэ.

**<u>Тэтгэлэг</u>.**

Улсын оюутны тэтгэлгэд өргөдөл гаргахад тавигдах нөхцлүүд:

- Социализм эх орноо хайрладаг, эв хамтын намын даргыг хамгаалдаг байх
- Үндсэн хууль болон хууль дүрмийг сахидаг, сургуулийн дүрэм журмыг сахидаг байх
- Үнэнч шударга итгэл даадаг, ёс суртахуун сахилга бат сайтай байх
- Идэвхитэй хичээн суралцдаг байх
- Гэр орны эдийн засгийн хүнд байдалтай, ариг гамтай амьдардаг байх зэрэг хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд өргөдөл гаргах эрх үүснэ.

*Өргөдөл гаргах, сонгон шалгаруулах ба олгох ерөнхий журам:* Улсаас олгох оюутны тэтгэлгийн сонгон шалгаруулалт жилд нэг удаа болно. Жил бүрийн 9 сарын 30-аас өмнө шалгаруулалт дуусна. Улс оюутны тэтгэлгийг 10 сараар олгоно. Их сургуулиас сар бүр улсаас өгөх сургалтын тэтгэлгийг сургалтын тэтгэлэгт хамрагдсан оюутны гарт олгоно.

Улсын оюутны тэтгэлгэд өргөдөл гаргагч оюутан нэг хичээлийн жилд өөр бусад улсын сурлагын мөнгөн шагнал, эсвэл улсын оюутан дэмжих тэтгэлэгт өргөдөл зэрэг гаргаж болно. Улсын хуулийн дагуу Их сургууль олсон орлогынхоо 4-6 хувийг ар гэрийн эдийн засгийн хүнд амьдралтай оюутанд тэтгэлэг болгон өгнө.

**<u>Зээл.</u>**

*Улсын сургалтын зээл олгох ажиллагааны дүрэм журам:* Тус журмыг 1999 оны 08 сарын 17-нд Боловсролын яам, Санхүүгийн яам, Хятадын төв банк болон Хятадын үйлдвэр арилжааны банкууд хэлэлцэн гаргав. Оюутанд олгох зээлийн хэмжээг тогтоохдоо дараахь томъёоны дагуу тогтооно. **Оюутанд олгох зээлийн хэмжээг тогтоох томъёо**: Оюутны зээлийн хэмжээ= сургалтын төлбөр + амьдарч байгаа хотын амьжиргааны өртөг - тус хүний орлого (гэрээс нь өгдөг орлого, нийгмийн бусад талын тусламжийн орлого зэрэг багтана). Тодруулан үзүүлбэл доорхи байдалтай байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН




Дүрмийн дагуу нэг хүнд жилд 6000 юанаас хэтрэхгүй хэмжээний зээл олгоно.

*Зээл олгогдох хүнд тавигдах шаардлага:*

- ❖ Бүрэн иргэний эрүүгийн хариуцлага хүлээх чадвартай байх
- ❖ Хууль дүрэм сахидаг, хууль зөрчиж байгаагүй байх
- ❖ Сурлагын дүн харьцангүй сайн байх
- ❖ Сургуульд суралцах үед олсон орлого нь сургалтын зардал болон амьжиргааны зардалдаа хүрэлцэхгүй байх
- ❖ Үнэнч шударга итгэл даадаг
- ❖ Хятадын үйлдвэр арилжааны банкны улсын сургалтын зээлийн арга хэмжээний тавигдсан нөхцлийг хангасан тохиолдолд зээл олгоно.

**<u>Сургалтын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт,</u>**

Тус улсын 2002 оны 9 сарын 1-ээс эхлэн хэрэгжсэн “Онцгой хүнд амьдралтай оюутныг сургалтын төлбөрөөс хөнгөвчлөх тогтоол” тогтоолын дагуу оюутныг сургалтын төлбөрөөс хөнгөлнө. Энэхүү тогтоолд “**Сургалтын төлбөрөөс чөлөөлөх стандарт”**-ыг тогтоосон байна.

Сургалтын төлбөрөөс чөлөөлөх стандарт нь:

- ✓ 3000Ґ (чөлөөлөх үзүүлэлт тэр жилийнхээ 30[1] -аас хэтрэхгүй)
- ✓ 2000Ґ гэсэн 2 ангилалтай.

Сургалтын төлбөрөөс чөлөөлөх харьцаа сургуулийн оюутны тооны 1[2] -иас хэтрэхгүй байна. Өргөдөл гаргагч оюутан хууль дүрэм журам, сургуулийн дүрэм журмыг сахидаг, сурлага сайн, бүх шалгалтандаа тэнцсэн байх ба дараахь нөхцлүүдийн нэгэнд заавал тохирсон байна.

*Чөлөөлөгдөх өргөдөл гаргагчид тавигдах шаардлага*:

a) Эцэг эхийн нь нас барсан, эдийн засгийн эх үүсвэргүй өнчин байх

b) Эцэг эх нь нас ахисан эсвэл тахир дутуу, хөдөлмөрийн чадвараа алдсан, ар гэрийн хүнд амьдралтай байх

c) Эцэг эх нь ажилгүй, тогтмол эдийн засгийн орлогогүй, ар гэрийн хүнд амьдралтай байх

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[1] http://gov.hnedu.cn/web/0/200510/09175013015.html

[2] http://gov.hnedu.cn/web/0/200510/09175013015.html

d) Хагас өнчин, гэр бүлийн орлого нь сургалтын төлбөрөө бүрэн төлөхөд хүрэлцэхгүй байх

e) Алслагдсан хөдөө орон нутгаас ирсэн, үндэсний цөөнх, маш хүнд амьдралтай байх

f) Цэргийн албанд харьяалагддаг байх (хамааралтай баримт бичиг үнэмлэх хавсаргах шаардлагатай)

g) Гэнэт үүссэн асуудал (байгалын гамшиг зэрэг) эсвэл бусад шалтгаанаас гэр бүлийн орлого гэнэт багассан, сургуульд суралцах хугацаанд сургалтын төлбөрийг төлөх чадваргүй байх зэрэг шаардлагуудыг хангасан байна.

**Оюутны сургалтын мөнгөн шагнал.**

Санхүүгийн яам, болон Боловсролын яамнаас 2007 оны 06 сарын 26-нд гаргасан "Энгийн дээд боловсролын сургууль, дээд боловсролын мэргэжил олгох сургуулиудын оюутны сурлагын мөнгөн шагнал удирдах түр хэрэгжүүлэх арга хэмжээ"[3] тогтоолоор улсаас сурлагын мөнгөн шагнал олгох харилцааг зохицуулна. Тус тогтоолоор нэг хүнд олгох жил бүрийн мөнгөн шагнал 8000 юань байхаар тогтдоогдсон байна.

Улсын оюутны сурлагын мөнгөн шагналд өргөдөл гаргахад тавигдах нөхцлүү*д*:

- ✓ Социализм эх орноо хайрладаг, эв хамтын намын даргыг хамгаалдаг байх.
- ✓ Үндсэн хууль болон хууль дүрмийг сахидаг, сургуулийн дүрэм журмыг сахидаг байх.
- ✓ Үнэнч шударга итгэл даадаг, ёс суртахуун сахилга бат сайтай байх.
- ✓ Сургуульд суралцах хугацаанд сурлагын дүн онц сайн, бүх талаараа онцгойрсон байх.

**Сонгон шалгаруулалт ба олгох:** Улсаас олгох оюутны тэтгэлгийн сонгон шалгаруулалт жилд нэг удаа болно. Сургууль бүр жил бүрийн хичээл эхлэх үед шалгаруулалтыг хийнэ. Шалгаруулалт 10 сарын 31-нд дуусна. Их сургууль жил бүрийн 11 сарын 30-аас өмнө нэг удаа шууд олгоно. Оюутны ар гэр эдийн засгийн асуудалтай байх эсэх нь хамаагүй бөгөөд зөвхөн тавигдсан нөхцөлд тэнцсэн оюутан л энэхүү мөнгөн шагналд хамрагдана.

**Оюутныг дэмжих мөнгөн шагнал**

Санхүүгийн яам, болон Боловсролын яамнаас 2007 оны 06 сарын 27-нд гаргасан "Энгийн дээд боловсролын сургууль, дээд боловсролын мэргэжил олгох сургуулиудын оюутныг дэмжих мөнгөн шагнал удирдах түр хэрэгжүүлэх арга хэмжээ" мэдэгдэл[4] -ийн дагуу улсаас олгодог оюутныг дэмжих мөнгөн шагнал нэг хүнд жил бүр 5000 юань байна.

Улсын оюутныг дэмжих мөнгөн шагналд өргөдөл гаргахад тавигдах нөхцлүүд:

- Социализм эх орноо хайрладаг, эв хамтын намын даргыг хамгаалдаг байх.
- Үндсэн хууль болон хууль дүрмийг сахидаг, сургуулийн дүрэм журмыг сахидаг байх.
- Үнэнч шударга итгэл даадаг, ёс суртахуун сахилга бат сайтай байх.

[4] http://xsc2000.sysu.edu.cn/Regulation/ShowArticle.asp?ArticleID=192

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Сурлагын дүн онц сайн байх.
- Гэр орны эдийн засгийн хүнд байдалтай, ариг гамтай амьдардаг байх зэрэг нөхцөл байдаг байна.

**Сонгон шалгаруулалт ба олгох:** Улсаас олгох оюутны тэтгэлгийн сонгон шалгаруулалт жилд нэг удаа болно. Сургууль бүр жил бүрийн хичээл эхлэх үед шалгаруулах ажлыг хийнэ. 10 сарын 31-нд дуусгана. Их сургууль жил бүрийн 11 сарын 30-аас өмнө нэг удаа шууд олгоно. Тухайн жилд энэ мөнгөн шагналыг авсан хүн өөр улсаас олгох тэтгэлгийг авч болохгүй.

**<u>Оюутны халамжийн тэтгэлэг</u>**

2004 онд тус улсын Санхүүгийн яамнаас “Оюутны гуанзны удирдлагыг сайжруулах мэдэгдэл”[5] гаргаж хүнд амьдралтай оюутанд өдөр бүр 4 юаны хоолны мөнгө олгох, оюутны хэрэглэх ус, цахилгаан, газны үнийг бусад айл өрхүүдийн тогтоосон үнээс хямд болгохоор шийдсэн байна. Энэхүү халамжийн тэтгэлэгт хамрагдах оюутнууд гэр орны эдийн засгийн хүнд байдалтай байх нөхцөлөөр хамрагдах ажээ.

Түүнчлэн “Багшийн их сургууль”-ийн багшийн ангийн оюутан үнэ төлбөргүй боловсрол эзэмших талаар мэдэгдэл[6] “Төрийн зөвлөлийн алба”-аас 2007 он 5 дугаар сарын 9-нд батлагдсан байна. Тус мэдэгдлээн сургуульд суралцах үеийн сургалтын төлбөрөөс чөлөөлөх, оюутны байрны төлбөрөөс чөлөөлөх, амьжиргааны мөнгө авах, бүх хэрэгцээтэй зардлыг улсын санхүү хариуцна.

**Тавигдах шаардлага:** Багшийн их сургуульд багшийн мэргэжлээр сурч байгаа бүх оюутан

Боловсролын яамнаас хэрэгжүүлдэг багшийн их сургуулийн багшийн мэргэжилд үнэгүй боловсрол олж авч байгаа оюутан улсын оюутны тэтгэлэгт давхар хамрагдахгүй.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[5] http://zzgl.hdu.edu.cn/shownews.asp?id=66

[6] http://www.chsi.com.cn/gjzxdk/zc/200708/20070810/1047223.html

| № | Эрх зүйн актууд | Төрийн дэмжлэгийн хэлбэр | Зээл болон бусад дэмжлэгт хамрагдах шалгуур үзүүлэлт | • Зээлийг эргэн төлөх журам<br>• Хариуцан хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|
| 1 | “Энгийн дээд боловсролын сургууль, дээд боловсролын мэргэжил олгох сургуулиудын оюутны тэтгэлэг удирдах түр хэрэгжүүлэх арга хэмжээ” мэдэгдэл Санхүүгийн боловсрол 2007 он дугаар 92<br>2 Санхүүгийн яам , боловсролын яамнаас гаргасан 2007.06.27 | Улсаас голдуу эдийн засгийн хүнд гэр бүлтэй оюутнуудад амьжиргааны зардал өгөх зорилгоор энэ оюутны тэтгэлгийг олгодог. Улсаас оюутны тэтгэлгийн хэмжээг дунджаар нэг оюутанд нэг жилийн 2000 Ұ аар тогтоодог. Бодит стандартыг жил бүр нэг оюутанд 1000-3000Ұ ны дотор тогтоодог. Үүнийг 2-3 зэрэглэлд ангилдаг. | Улсын оюутны тэтгэлгэд өргөдөл гаргахад тавигдах нөхцлүүд:<br>1. Социализм эх орноо хайрладаг, эв хамтын намын даргыг хамгаалдаг байх.<br>2. Үндсэн хууль болон хууль дүрмийг сахидаг, сургуулийн дүрэм журмыг сахидаг байх.<br>3. Үнэнч шударга итгэл даадаг, ёс суртахуун сахилга бат сайтай байх.<br>4. Идэвхитэй хичээн суралцдаг байх.<br>5. Гэр орны эдийн засгийн хүнд байдалтай, ариг гамтай амьдардаг байх. | • Буцаж төлөхгүй.<br>• Санхүүгийн яам , Боловсролын яам. |
| 2 | Улсын сургалтын зээл олгох ажиллагааны дүрэм журам<br><br>1999.8.17нд боловсролын яам, санхүүгийн яам, Хятадын төв банк болон Хятадын үйлдвэр арилжааны банкууд хэлэлцэн гаргав. | Оюутанд олгох зээлийн хэмжээг тогтоох<br>Оюутанд олгох зээлийн хэмжээг тогтоох томъёо: оюутны зээлийн хэмжээ = сургалтын төлбөр + амьдарч байгаа хотын амьжиргааны өртөг - тус хүний орлого (гэрээс нь өгдөг орлого, нийгмийн бусад талын тусламжийн орлого зэрэг багтана) . Дүрмийн дагуу нэг хүнд жилд 6000Ұ аас хэтрэхгүй. | Зээл олгогдох хүнд тавигдах шаардлага:<br>1. бүрэн иргэний эрүүгийн хариуцлага хүлээх чадвартай байх.<br>2. хууль дүрэм сахидаг, хууль зөрчиж байгаагүй байх.<br>3. сурлагын дүн харьцангуй сайн байх<br>4. сургуульд суралцах үед олсон орлого нь сургалтын зардал болон амьжиргааны зардалдаа хүрэлцэхгүй байх<br>5. Үнэнч шударга итгэл даадаг<br>6. Хятадын үйлдвэр арилжааны банкны улсын сургалтын зээлийн арга хэмжээний тавигдсан нөхцлийг хангах | • Улсаас олгосон зээлийн хугацаа зээлдэгч сургуулиа төгссөнөөс хойш 4 жилээс хэтрэхгүй. Улсаас олгосон зээлийн хүүгийн хувийг Хятадын Ардын банкны тогтоосон хүүгийн хувь болон улсын хүүгийн хувьтай холбоотой бодлогоор хэрэгжүүлнэ<br>• Санхүүгийн яам , Боловсролын яам. Хятадын үйлдвэр арилжааны банкууд |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Онцгой хүнд амьдралтай оюутныг сургалтын төлбөрөөс хөнгөвчлөх тогтоол<br><br>Энэ тогтоолыг 2002.09.01 ээс эхлэн хэрэгжүүлнэ.<br><br>http://xsc2000.sysu.edu.cn/Regulation/ShowArticle.asp?ArticleID=192 | Сургалтын төлбөрөөс чөлөөлөх стандарт Сургалтын төлбөрөөс чөлөөлөх стандарт нь 3000Ґ (чөлөөлөх үзүүлэлт тэр жилийнхээ 30□аас хэтрэхгүй) мөн 2000Ґ гэсэн 2 ангилалтай. Сургалтын төлбөрөөс чөлөөлөх харьцаа сургуулийн оюутны тооны 1 □ ийн дотор байх. | Өргөдөл гаргагчид тавигдах шаардлага:<br>Өргөдөл гаргагч оюутан хууль дүрэм журам, сургуулийн дүрэм журмыг сахидаг, сурлага сайн, бүх шалгалтандаа тэнцсэн дараах нөхцлүүдийн нэгэнд заавал тохирсон байх:<br>1.Эцэг эхийн нь нас барсан, эдийн засгийн эх үүсвэргүй өнчин байх<br>2.Эцэг эх нь нас ахисан эсвэл тахир дутуу, хөдөлмөрийн чадвараа алдсан, ар гэрийн хүнд амьдралтай байх<br>3.Эцэг эх нь ажилгүй, тогтмол эдийн засгийн орлогогүй, ар гэрийн хүнд амьдралтай байх<br>4.Хагас өнчин, гэр бүлийн орлого нь сургалтын төлбөрөө бүрэн төлөхөд хүрэлцэхгүй байх<br>5.Алслагдсан хөдөө орон нутгаас ирсэн, үндэсний цөөнх, маш хүнд амьдралтай байх<br>6.Цэргийн албанд харьяалагддаг байх (хамааралтай баримт бичиг үнэмлэх хавсаргах шаардлагатай)<br>7.Гэнэт үүссэн асуудал (байгалын гамшиг зэрэг) эсвэл бусад шалтгаанаас гэр бүлийн орлого гэнэт багассан, сургуульд суралцах хугацаанд сургалтын төлбөрийг төлөх аргагүй байх. | • Буцаан төлөхгүй.<br>• Энэ тогтоолыг оюутны тусламжийг удирдах зөвлөлийх хурал хариуцан тайлбарлана. |
| 4 | □ Энгийн дээд боловсролын сургууль, дээд боловсролын мэргэжил олгох сургуулиудын оюутны сурлагын мөнгөн шагнал удирдах түр хэрэгжүүлэх арга хэмжээ□ мэдэгдэл Санхүүгийн боловсрол 2007 он дугаар 90<br>Санхүүгийн яам , боловсролын яамнаас гаргасан 2007.06.26<br>http://zzgl.hdu.edu.cn/shownews.asp?id=66 | Улсаас олгодог сурлагын мөнгөн шагнал нэг хүнд жил бүр 8000Ґ байна. | Улсын оюутны сурлагын мөнгөн шагналд өргөдөл гаргахад тавигдах нөхцлүүд:<br>1. Социализм эх орноо хайрладаг, эв хамтын намын даргыг хамгаалдаг байх.<br>2. Үндсэн хууль болон хууль дүрмийг сахидаг, сургуулийн дүрэм журмыг сахидаг байх.<br>3. Үнэнч шударга итгэл даадаг, ёс суртахуун сахилга бат сайтай байх.<br>4.Сургуульд суралцах хугацаанд сурлагын дүн онц сайн, бүх талаараа онцгойрсон байх. | • Буцаан төлөхгүй.<br>• Санхүүгийн яам , Боловсролын яам. |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | Энгийн дээд боловсролын сургууль, дээд боловсролын мэргэжил олгох сургуулиудын оюутныг дэмжих мөнгөн шагнал удирдах түр хэрэгжүүлэх арга хэмжээ мэдэгдэл Санхүүгийн боловсрол 2007 он дугаар 91 Санхүүгийн яам , боловсролын яамнаас гаргасан 2007.06.27 | Улсаас олгодог оюутныг дэмжих мөнгөн шагнал нэг хүнд жил бүр 5000Ґ байна. | Улсын оюутныг дэмжих мөнгөн шагналд өргөдөл гаргахад тавигдах нөхцлүүд:<br>1. Социализм эх орноо хайрладаг, эв хамтын намын даргыг хамгаалдаг байх.<br>2. Үндсэн хууль болон хууль дүрмийг сахидаг, сургуулийн дүрэм журмыг сахидаг байх.<br>3. Үнэнч шударга итгэл даадаг, ёс суртахуун сахилга бат сайтай байх.<br>4. Сурлагын дүн онц сайн байх.<br>5. Гэр орны эдийн засгийн хүнд байдалтай, ариг гамтай амьдардаг байх. | • Буцаан төлөхгүй.<br>• Санхүүгийн яам Боловсролын яам. |
| 6 | Оюутны гуанзны удирдлагыг сайжруулах мэдэгдэл Санхүүгийн боловсрол 2004 он дугаар 15 | Сургуулийн хүнд амьдралтай оюутанд өдөр бүр 4Ґ ны хоолны мөнгө олгох.<br>Оюутны хэрэглэх ус, цахилгаан, газны үнийг бусад айл өрхүүдийн тогтоосон үнээс хямд болгох. | Гэр орны эдийн засгийн хүнд байдалтай байх. | • Буцаан төлөхгүй |
| 7 | Багшийн их сургуулийн багшийн ангийн оюутан үнэ төлбөргүй боловсрол эзэмших талаар мэдэгдэл Төрийн зөвлөлийн алба 2007 он дугаар 34 2007.05.09 | Сургуульд суралцах үеийн сургалтын төлбөрөөс чөлөөлөх, оюутны байрны төлбөрөөс чөлөөлөх, амьжиргааны мөнгө авах, бүх хэрэгцээтэй зардлыг улсын санхүү хариуцна. | Багшийн их сургуульд багшийн мэргэжлээр сурч байгаа бүх оюутан | • Буцаан төлөхгүй<br>• Төрийн зөвлөлийн алба |

**БНСУ -ын ТУРШЛАГА**

***БНСУ-ын дээд боловсролын тогтолцоо***

БНСУ -д 175 их сургууль, 14 аж үйлдвэрийн их сургууль, 11 боловсролын их сургууль, 148 коллеж болон бусад төрлийн дээд боловсролын нийт 408 сургууль байдаг. Эдгээр 408 дээд боловсрол олгодог байгууллагуудын 54 нь төрийн өмчит бөгөөд 354 нь хувийн өмчийн сургуулиуд байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Дээд сургууль нь 7-н категоруудад хуваагддаг. Үүнд*

1. *Коллеж, их сургууль,*
2. *Аж үйлдвэрийн сургууль,*
3. *Боловсролын сургууль,*
4. *Бага коллеж,*
5. *Нисэх болон сэтгүүлчийн сургууль*

6. *Техникийн коллеж,*
7. *Шашны коллеж ба бусад*

БНСУ-ын Боловсролын яам нь хуулийн чиглэлийн улсын болон хувийн бүх сургуулиудыг хянадаг. Боловсролын яам оюутнуудын тоо, багш нарын ур чадвар, зэргийн шаардлага зэргийг хянадаг байна.

- Их сургуулиуд

Коллежийн боловсролын сургалтын хугацаа нь 4-6 жил байдаг. Их сургуульд хичээлийн төгсөлтийг хэмжих нэгж нь кредит юм. Их сургууль бүр төгсөхөд шаардлагатай минимум кредит, семестр болгоны максимум кредитыг хянадаг. Сургалтын хөтөлбөр нь ерөнхий болон мэргэжлийн курсээс бүрдэх ба энэ нь бас заавал сурах болон сонгомол курс гэж хуваагдана.

- Боловсролын сургууль

Боловсролын сургууль нь бага болон дунд сургуулийн багш нарыг сургадаг. Боловсролын бүх сургуулиуд нь дотоодын, 4  жилийн курстэй байдаг. Их сургуулийн сургалтын хөтөлбөр гол салбар, либерал салбар гэж хуваагдана. Гол салбар нь ерөнхий мэдлэг болон багшлах хичээлүүдээс бүрдэнэ. Ерөнхий мэдлэгийн хичээлээс оюутнууд анхан шатны сургуулийн багш нарын мэдлэгийг олж авдаг. Багшлах хичээлээс багшлах арга, үндэсний боловсролын үзэл санаанаас суралцдаг.

- Солонгосын үндэсний боловсролын сургууль

Цэцэрлэг, бага болон дунд сургуульд багшлахад зориулж багш бэлтгэх туршилтын журмаар 1985 онд Солонгосын үндэсний боловсролын сургуулийг байгуулсан.

- Бага коллеж

Бага коллеж нь 2-3 жилийн хичээлийн сургалттай. Бага коллежийн боловсролын зорилго нь үндэсний хөгжилд нийгмийн ямар ч салбарт техникийн судалгаа хийх, багшлахад өөрсдийгөө зориулж чадах дунд түвшний техникчдийг бэлтгэх явдал юм. 2-3 жилийн сургалттай мэргэжлийн курс нь анагаахын, физик, урлагийн, инженерын, байгалийн шинжлэх ухаан, хүмүүнлэг болон нийгмийн сургалтын гэж байна.

Дээд сургуульд ороход ерөнхийдөө ахлах сургууль төгссөн дүн ба жил болгоны улсын шалгалтын дүн шаардлагатай байдаг. Сурагч өөрийнхөө хүссэн сургуульд элсэхийг хүссэн өргөдөл гаргаж болох боловч тухайн сургуулиас шалтгаалан оюутан элсүүлж авах дотоод дүрэм бага зэрэг ялгаатай байдаг тул тухайн сургуулиас шаардаж буй болзлыг хангасан байх шаардлагатай.   Эцэг эх нь хоёулаа гадаад хүн бол гадаад оюутан элсүүлэн авах материалтай танилцан материалаа бүрдүүлж өгнө.

*Зардал*

Дотоодын оюутнуудын сургалтын төлбөр сургалтын зардал, лаботорийн зардлаас бүрдэх төлбөрийг сургуулийн санхүүгийн хэлтэст төлнө.

1-р хичээлийн семестрт лабораторийн болон сургалтын, шинээр элсэнийг багтаасан төлбөрийг оюутан нь төлөх шаардлагатай.

2-р семестрын эхэнд оюутан зөвхөн лабороторийн, сургалтын төлбөрийг төлнө.

*Их сургуулийн сургалтын тэтгэлэг*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БНСУ -ын төрөөс дотоодын оюутнууддаа сургалтын тэтгэлэг, зээлийг олгодог. Нийтлэг тэтгэлэг олгох гол шалгуурыг оюутны чадвар, санхүүгийн чадамжийг чухалчлан авч үздэг.

БНСУ-д оюутны тэтгэлгийг их, дээд сургуулиуд дотоод журам болон сургуулийн суралцаж буй мэргэжлийн чиглэл онцлогоос хамааруулан ялгавартайгаар тогтоодог байна. Солонгосын их, дээд сургууль, коллежууд нь тус бүр дотоодын тэтгэлгийн хэлбэртэй байдаг байна.

*Тухайлбал нийтлэг тэтгэлгийн хэлбэрүүд нь:*

- Багш, профессоруудын саналаар хамгийн сайн суралцаж буй оюутнуудын 30% нь сургалтын төлбөрөөс чөлөөлөх,
- Нийт суралцаж буй дотоодын оюутнуудын 45.4%- 75 хувь нь ийг ямар нэгэн хэмжээгээр тэтгэлэг, хөнгөлөлтөнд  хамрагдахаас
- Оюутнуудын 30% нь багшийн санал болгосноор 100%-ийн сургалтын төлбөрөөс чөлөөлөгдөх
- Хоёр төрлийн тэтгэлэгт хөтөлбөртэй, A – сургалтын төлбөрөөс бүрэн чөлөөлнө, сарын 500 000 воны стипендтэй, B – сургалтын төлбөрийн 50%-ийг чөлөөлнө. / *Энэ тэтгэлэгийг хичээлдээ амжилттай суралцсан оюутанд өгдөг бөгөөд тухайн оюутны суралцаж буй салбар чиглэлээс хамаарч ялгавартай тогтоох*

**БНСУ-ын оюутны зээлийн төрөл**

| | Ministry Of Educations Income Contingent loan Program Боловсролын яамны төсвөөс санхүүждэг зээлийн хөтөлбөр | MOE Government Guaranteed Loan Scheme Боловсролын яам, засгийн газраас баталгаажсан зээл | Korea Research Foundation<br><br>Солонгос судлалын сан |
|---|---|---|---|
| Хэрэгжиж эхэлсэн огноо | 2010 | 2005 | 1999 |
| Хамрагдах оюутнуудын шалгуур | Ядуу оюутан | Ядуу оюутан | Мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр суралцаж байгаа болон бусад оюутнуудад |
| Санхүүжилт | Солонгос оюутны дэмжлэгийн сан<br><br>Korea Student Aid Foundation | Арилжааны банк | Солонгос судлалын сан |
| Зээлийн хуваарилалт, эргэн төлөлт | Боловсролын яам | Арилжааны банк | Солонгос судлалын сан |

UILMN СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
| Баталгаа гаргах | Баталгаа гаргахгүй | Оюутны зээл хүсэгч нь банкинд баталгаа гаргана. | Сургалтын кредит бүрэн байх |
| Хүүгийн хувь, хэмжээ | 5,8 % | Ядуу оюутнуудад тэтгэлгийн хэмжээг хүүгүй олгоно. Бусад оюутнуудын хувьд 2-6,66% хүүтэй | Хүүгүй |
| Эргэн төлөлт | Тодорхой ажил эрхэлж 25 жилийн дотор төлөх | 20 жил | Төгссөнөөс хойш 1 жилийн дараагаас эхлэн төлнө |
| Дээд боловсролын зардлын төрөл | Сургалтын хагас тэтгэлэг болон амьжиргааны тэтгэлэг | Бүрэн тэтгэлэг болон амьжиргааны хагас тэтгэлэг | Сургалтын хагас тэтгэлэг |

**БНСУ-ын их дээд сургуульд дотоодын болон гадаадын оюутнуудын тэтгэлгээр сурах боломж**[7]

| д | БНСУ-ын их сургуулиуд | Ерөнхий мэдээлэл | Тэтгэлэгт хамрагдах боломж | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. | Пусаны Улсын их сургууль | 1946 онд байгуулагдсан, 3 000 орчим оюутантай. Японы Фукуокагийн боловсролын их сургууль, Шиманэгийн их сургууль, БНХАУ-ын Ханзоу-гийн их сургууль, АНУ-ын Илланоис Улсын их сургуультай хамтын ажиллагаатай | Багш, профессоруудын саналаар хамгийн сайн суралцаж буй оюутнуудын 30% нь сургалтын төлбөрөөс чөлөөлөгддөг. | |
| 2. | Чоннамийн Улсын их сургууль | 1952 онд байгуулагдсан, 28662 оюутантай багш оюутны харьцаа 1:23, Япон Улсад 29 сургууль, Хятадад 27 сургууль, АНУ-д 18 сургууль, Вьетнамд 12 сургууль, бусад улс орнуудад 41 сургуультай солилцоо, хамтын ажиллагааны хөтөлбөртэй | Тус сургууль нь жил бүр дунджаар нийт 26.3 тэрбум воныг тэтгэлэгт төсөвлөдөг, өөрийн оюутнуудын 45.4%-ийг ямар нэгэн хэмжээгээр тэтгэлэгт хамруулдаг | Солонгос хэлний курстэй |
| 3. | Чунчоны Улсын Боловсролын их сургууль | 1939 онд байгуулагдсан, 2564 оюутантай, багш оюутны харьцаа 1:50 | Оюутны чадвар, санхүүгийн чадамжаас шалтгаалан олгох 24 төрлийн тэтгэлэг байдаг. | Ерөнхий боловсролтой холбоотой асуудал, боловсролын системийн менежмент |

7 http://www.mongolembassy.com/

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4. | Чунбукийн улсын их сургууль | 1951 онд байгуулагдсан, 19400 оюутантай, багш оюутны харьцаа 1:25 | Чунбукийн улсын их сургуулийн хөгжлийн сангаас жил бүр хоёр оюутанд 12 000 ам долларын тэтгэлэг олгодог | |
| 5. | Гёнгсан Улсын их сургууль | 1948 онд байгуулагдсан, багш оюутны харьцаа 1:36, Гадаадын 62 их дээд сургуультай 92 солилцооны оюутны хөтөлбөртэй | Тус сургуулийн оюутнуудад Гёнгсан Улсын их сургуулийн тэтгэлэг, тус сургуулийн сангийн тэтгэлэг, Өмнөд солонгосын Засгийн газрын тэтгэлэг гэсэн 3 төрлийн тэтгэлэгт хамтрагдан суралцдаг | Солонгос хэлний сургалттай |
| 6. | Ханбат Улсын их сургууль | 1927 онд байгуулагдсан, 9 471 оюутантай, 165 гадаадын оюутантай. Гадаадын 9 оронд 35 их дээд сургуультай харилцаатай | Хамтын ажиллагааны хөтөлбөртэй их дээд сургуулиудаас 100% тэтгэлэг олгодог, гадаадын оюутнуудын хувьд голч дүн нь 3.5-аас дээш бол 100%, 3.00 аас дээш бол 50%-ийн тэтгэлэг олгоно | Мэдээллийн технологийн чиглэлээр сайн |
